

**СЭЛЭНГЭ АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ, СУМДЫН
2018 ОНЫ 06 ДУГААР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2018.07.04

Сүхбаатар сум

Нэг.Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:

1.Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 06 дугаар сард 3 удаа хуралдаж, 25 асуудал хэлэлцэн 30 тогтоол баталсан.Үүнд:

-2021 онд тохиох Монгол Улсад Ардын хувьсгал ялсны түүхт 100 жил, Сэлэнгэ аймаг байгуулагдсаны 90 жилийн ойг угтаж аймгийн хэмжээнд “Сэлэнгэ-90” бүтээлч ажлын 3 жилийн аяныг 2019 оноос эхлэн өрнүүлж ажиллахаар тогтоолоо.

-Өсвөр үе, залуучуудыг бие даах чадвар болон амьдрах ухаанд сургаж, хөдөлмөр эрхлэх нөхцөл, ажлын байраар хангах, тэдний нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэн зохих түвшинд шийдвэрлэх зорилго бүхий “Залууст боломж” аймгийн хөтөлбөр, хүүхэд бүрт суурь боловсролыг чанартай хүргэж эрүүл чийрэг, эерэг зан суртахуун, гоо зүйн хүмүүжлийг олгож амьдрах ухаантай, эх оронч сэтгэлгээтэй иргэнийг төлөвшүүлэх зорилго бүхий “Бид Сэлэнгийн ирээдүй” аймгийн, нийгмийн оролцоонд гэр бүлийн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, амьдралын үнэ цэнийг ойлгуулах, чадамжийг сайжруулах, гэр бүлийн уламжлалт ёс заншлыг сэргээн хөгжүүлэх зорилгоор “Жаргалтай гэр бүл” аймгийн хөтөлбөр, Засаг захиргааны анхан шатны нэгж багийн удирдлага, ажлын албыг сахилга хариуцлага, ёс зүйтэй, мэдлэг чадвартай төрийн албан хаагчдаар бүрдүүлж, нэгдсэн бодлого зохицуулалтаар өрсөлдөх чадвар, эдийн засаг, нийгмийн суурь үзүүлэлтүүдийг нэмэгдүүлэх, иргэдийнхээ амьдралын түвшинг сайжруулан, багийн чадавхийг бэхжүүлж, төвлөрлийг сааруулах зорилготой “Багийн хөгжлийн хөтөлбөр”, орчин үеийн дэвшилтэт техник технологийг төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлд нэвтрүүлж салбарын тогтвортой хөгжлийг ханган хүнсний ногооны төрөл зүйлийг нэмэгдүүлж Сэлэнгэ брэндийг бий болгон улсын хэмжээний үйлдвэрлэлд эзлэх байр суурийг өсгөн гадаад зах зээлд нийлүүлэх боломжийг хангах зорилгоор “Сэлэнгэ төмс, хүнсний ногоо” аймгийн хөтөлбөрийг тус тус баталсан.

-Баянгол сумын Эрүүл мэндийн төв үүсч байгуулагдсаны 80 жилийн ойг 2018 оны 07 дугаар сард, Сүхбаатар сумын 12 жилийн 3 дугаар дунд сургуулийн 50 жилийн ойг 2018 оны 10 дугаар сард, Сант сумын ЕБ-ын 12 жилийн дунд сургуулийн үүсч байгуулагдсаны 70 жилийн ойг 2018 оны 11 дүгээр сард, мөн сумын 13 дугаар цэцэрлэгийн 60 жилийн ойг 2018 оны 11 дүгээр сард, Орхон сумын 12 дугаар цэцэрлэг үүсч байгуулагдсаны 60 жилийн ойг 2018 оны 10 дугаар сард тэмдэглэн өнгөрүүлэхийг зөвшөөрөв.

-Боловсролын байгууллагад олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажилласан Сүхбаатар сумын ахмад настан Равжирын Сэр-Одыг Монгол Улсын Гавьяат багш цолоор, хөдөө аж ахуй, газар тариалангийн салбарт олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж хадлан тэжээл бэлтгэх, үр тарианы үйлдвэрлэлийг хөгжүүлэн арвин ургац тогтмол хурааж, хөдөө аж ахуйн салбарыг хөгжүүлэхэд оруулсан хувь нэмрийг нь үнэлж Цагааннуур сумын “Номунхан” ХХК-ий бригадын дарга Цэвэлийн Шавлайг “Хөдөө аж ахуйн гавьяат механикжуулагч” цолоор, эрхэлсэн ажилдаа амжилт бүтээл гаргаж ажилласан зарим хүмүүсийг төрийн одон, медалиар шагнуулахаар МУ-ын Ерөнхийлөгчид уламжиллаа. Үүнд: Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонгоор 7, Цэргийн гавьяаны улаан тугийн одонгоор 3, Цэргийн гавьяаны одонгоор 2, Алтан гадас одонгоор 29, Цэргийн хүндэт медалиар 7, Хөдөлмөрийн хүндэт медалиар 33 хүнийг уламжлав.

-Сэлэнгэ аймаг, ОХУ-ын Буриад улсын найрсаг харилцаа, хамтын ажиллагаанд үнэтэй хувь нэмэр оруулж, хоёр орны болон бүс нутгийн гадаад харилцааны асуудалд

дорвитой хүчин зүтгэл гарган ажилласныг нь үнэлж ОХУ-ын Буриад улсын Хиагтын районы дарга А.В.Буянтуевыг Сэлэнгэ аймгийн “Хүндэт тэмдэг”-ээр шагнав.

-ОНӨААТҮГ-ын 2017 оны үйл ажиллагааны тайланг хэлэлцэн цаашид анхаарах асуудлын талаар чиглэл өгч, тогтоолыг гаргаж, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2017 оны 12-р сарын 22-ны өдрийн “Зөвшөөрөл олгох тухай” 160 дугаар тогтоолын “Түшиг чуулган” гэснийг “Түшиг цуглаан” болгон өөрчлөн тогтоов.

Ардын хувьсгалын 97 жилийн ойн аймгийн баяр наадмын төсвийг 65 655 350 төгрөгөөр баталж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Х хуралдааныг 2018 оны 07-р сарын 02-ны өдөр аймгийн төв Сүхбаатар суманд хуралдуулахаар товыг тогтоов.

-Хөдөлмөр халамжийн үйлчилгээний газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй тээврийн хэрэгслийг аймгийн Статистикийн хэлтэст балансаас балансад шилжүүлэхийг, аймгийн ХХААГ-ын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга эд хогшлыг Мал эмнэлгийн албаны балансад шилжүүлэхийг зөвшөөрөв.

Энэ сард аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 05-р сарын 01-ний өдрийн "Ажлын хэсэг байгуулах тухай" 34 дүгээр тогтоолын дагуу Сэлэнгэ аймгийн Ерөө, Хүдэр сумын нутаг дэвсгэрт уул уурхайн үйл ажиллагаа явуулж буй "Болд төмөр Ерөө гол" ХХК, "Дархан төмөрлөгийн үйлдвэр" ХК-ий үйл ажиллагаанд холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, аймаг, сум орон нутагтай хамтран ажиллаж буй байдлыг шалган танилцаж дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг 2018 оны 06-р сарын 12, 13-ны өдрүүдэд удирдамжийн дагуу шалган танилцах ажлыг явууллаа. Мөн аймгийн ИТХ-ын даргын баталсан удирдамжийн дагуу Сайхан сумын Номгон 3-р багийн нутагт байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдлыг судлах, Ширээ нуруу орчимд ой мод, түгээмэл тархацтай ашигт малтмалыг хууль бусаар огтолж, олборлож байгаа нөхцөл байдлыг газар дээр нь шалган танилцах, Хог хаягдлын тухай хууль, Эрүүл ахуйн тухай хуулийн хэрэгжилтийн байдалтай танилцаж, тулгарч буй хүндрэл бэрхшээлийг судлах, Ширээ нуруу орчмын айл өрх, иргэдийн шилжилт хөдөлгөөнтэй холбоотой үүсээд буй хүндрэлтэй асуудлууд, түүнийг дагасан гэмт хэрэг, зөрчлийн нөхцөл байдалтай танилцах зорилго бүхий ажлын хэсэг байгуулагдаж 2018 оны 06-р сарын 15-ны өдөр удирдамжийн дагуу ажиллалаа.

2. Аймгийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:

Аймгийн хэмжээнд 2018 онд нийт 193418 га буюу 119187 га-д уринш, 74230 га-д гуурсанд тариалсан. Үр тариа, төмс, хүнсний ногооны тариалалтын мэдээгээр 6-р сарын 25-ны байдлаар 150504 га-д үр тариа, үүнээс 140625 га-д улаанбуудай, 9879 га-д бусад үр тариа, 15643 га-д тэжээлийн ургамал, 28624 га-д тосны ургамал тариалж, 2654 га-д төмс, 2638 га-д хүнсний ногоо тариалсан. Тариалсан талбайг соёлолтын дүнгээр үнэлэхэд 28560 га нь буюу 19 хувь нь онц, 87543 га буюу 58,2 хувь нь сайн, 33569 га буюу 22 хувь нь дунд, 746 га буюу 0,4 муу хувьтай байна.

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн 2018 оны эхний хагас жилийн тайланг Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 89-р тогтоолын дагуу “Unelgee.gov.mn” сайтад аймагт хамааралтай хяналтанд авагдсан 134 зүйл заалтын хэрэгжилтийг 76,56 хувийн гүйцэтгэлтэйгээр тайлагналаа.

Мандал, Сүхбаатар, Сайхан, Ерөө сумдад төрийн үйлчилгээний цахим машиныг байршуулан төрийн үйлчилгээг шуурхай хүргэн ажиллаж байгаа бөгөөд 2018 оны эхний хагас жилд нийт 23 төрлийн лавлагаа, тодорхойлолт зэргийг давхардсан тоогоор 13086 иргэн авсан байна.

“Тосгодын тулгамдсан асуудал, түүнийг шийдвэрлэх арга замууд” сэдэвт хэлэлцүүлгийг 6-р сарын 22-нд Бугант тосгонд зохион байгууллаа. Арга хэмжээнд аймгийн ИТХ-ын Тэргүүлэгч О.Буянаа, Ж.Наранцэцэг, Д.Пүрэвдорж, Д.Ганбаатар, аймгийн ЗДТГ-ын дарга, хэлтсийн дарга нар болон Мандал сумын ИТХ-ын дарга Д.Ганболд, Бугант, Түнхэл, Хэрх, Дулаанхаан, Рашаант, Номгон тосгодын захирагчид, захирагчийн албаны албан хаагчид оролцлоо. Тус аймаг нь 6 тосгонтой бөгөөд 20 орчим хүний бүрэлдэхүүнтэй захирагчийн ажлын алба төрийн үйлчилгээг иргэдэд хүргэж байгаа бөгөөд харилцан туршлага солилцох, тулгамдаж буй бэрхшээлийн

талаараа ярилцаж, зарим тосгодыг сум болгох асудлыг холбогдох дээд шатны байгууллагад уламжлах талаар хэлэлцлээ.

Аймгийн “Ногоочдын уулзалт, сургалт”-ыг Сүхбаатар суманд зохион байгуулж, 17 сумын 200 ногоочдыг хамрууллаа. Уулзалт, сургалтаар аймгаас ногоочдын талаар баримтлах бодлого, чиглэлийг тодорхойлох, харилцан туршлага судлах, санал бодлыг сонсох, “Жимс жимсгэнэ хөтөлбөр”-ийн төсөлд санал авч хэлэлцүүлэг хийлээ.

Мөн аймгийн Засаг даргын тамгын газар, Тогоочдын холбоотой хамтран “Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажилчдын анхдугаар зөвлөгөөн, ажил мэргэжлийн уралдаан”-ыг 2018 оны 05 дугаар сарын 29-ний өдөр тогоочдын ур чадварыг дээшлүүлэх, орон нутгийн онцлогтой хоол идээ ундааг бий болгох, сурталчлан таниулах, харилцан туршлага судлах, түгээх зорилгоор аймгийн төвд зохион байгуулж, 16 сумын 150 гаруй хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын төлөөлөл оролцуулсан. Энэхүү арга хэмжээний үеэр тогоочдын нэгдсэн парад жагсаал, ажил мэргэжлийн уралдаан болсон. Тогоочдын мэргэжлийн ур чадварын уралдаан”-д 10 сумын 24 тогооч 2 төрөлд авъяас чадвараа сорин өрсөлдөж, “Шилдэг зохион байгуулалттай оролцсон сум”-аар Хүдэр сум, нийтийн хоолны төрөлд “Тэргүүн байр, алтан медаль”-ыг Цагааннуур сумын “Хангай” цайны газрын тогооч Н.Отгонбаяр, “Дэд байр, мөнгөн медаль”-ыг Сүхбаатар сумын “Шинэ бадрах” ХХК-ний тогооч А.Лхагвадорж, “Гуравдугаар байр, хүрэл медаль”-ыг Хүдэр сумын “Унаган нутаг” цайны газрын тогооч В.Амарзаяа, цэцэрлэг, сургууль, албан байгууллагын дэргэдэх хоол үйлдвэрлэлийн төрөлд “Тэргүүн байр, алтан медаль”-ыг Сайхан сумын Хөтөл ЕБС-ийн тогооч Ц.Нямаа “Дэд байр, мөнгөн медаль”-ыг Шаамар сумын ЕБС-ийн тогооч Ш.Энхжаргал, “Гуравдугаар байр, хүрэл медаль”-ыг Түшиг сумын цэцэрлэгийн тогооч Ц.Цогзолмаа нар шалгарлаа.

Аймгийн барилга, эрчим хүчний салбарын уулзалт, зөвлөгөөнийг төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтын ажлуудад төр, хувийн хэвшил, төрийн бус байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, үйл ажиллагааг нь эрчимжүүлэх, байгаль орчинд ээлтэй, эко барилга байгууламж барих, эрчим хүчний хэмнэлтийг бий болгох, улс, орнуудын туршлагыг судлах, орон нутагтаа хэрхэн нутагшуулах талаар зөвлөлдөж, Эрчим хүчний хэмнэлтийн тухай, барилгын тухай хууль, тогтоомж, дүрэм журмыг хэрэгжүүлэх талаар сургалт хийлээ.

Монгол Улсын Сэлэнгэ аймаг, ОХУ-ын Буриад Улсын хил дагуу аймгуудын дунд уламжлал болон зохион байгуулагддаг “Эв модны наадам” энэ сарын 11-ний өдөр ОХУ-ын Буриад Улсын Хиагт хотод болсон. Энэ удаагийн наадам нь ОХУ-ын Буриад Улсын Хиагт хот үүсэн байгуулагдсаны 290, Хиагтын район байгуулагдсаны 95 жилийн түүхэн ойтой давхцсан бөгөөд “Торгон угтахан”, загвар зохион бүтээгчдийн уралдаан “Үзэсгэлэн гоо” тэмцээн, “Эстрадын болон ардын дуу, Үндэсний хөгжим, Буриад бөх, сур харвааны тэмцээнүүд явагдаж шилдгүүдээ тодруулсан. Наадмын урлагийн төрөлд тус аймгаас 2 алт, 1 мөнгө, бөхийн барилдаанд 1 алт, 1 мөнгө, 1 хүрэл, загвар зохион бүтээгчийн төрөлд Гран при буюу алтан медаль, “Үзэсгэлэн гоо” тэмцээнд 2, 3-р байрыг эзэлж, амжилттай оролцлоо.

Стандарт, хэмжил зүйн ажил үйлчилгээний талаар:

“Газрын тосны салбарын ажилтны өдөр”, “Дэлхийн хэмжил зүйн өдөр” -ийг тохиолдуулан Шатахуун түгээх газрын ажилтнуудын дунд “Чадварлаг хамт олон” сэдэвт ажил мэргэжлийн уралдаан, спортын тэмцээнийг тэдгээрийн мэдлэг, чадварыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцох, хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор 06 сарын 06-ны өдөр зохион байгууллаа. Арга хэмжээний хүрээнд хэмжилзүйн талаарх мэдээлэл, шатахуун түгээх станц Техникийн шаардлага MNS 4628-2013 стандар, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагаа, шатахуунаар хангах мэргэжлийн анги, анхан шатны тусламж үзүүлэх талаар сургалт хийж, Сүхбаатар, Шаамар сумдын 6 байгууллагын 34 ажилтан хамрагдсан. Мөн ажил мэргэжлийн уралдааныг 06-р сарын 19-ны өдөр “Их Монгол” амралтын газар зохион байгуулж “НИК”, “Шунхлай”, “Тэс Петролиум”, “Сод Монгол”, “Дашваанжил” ХХК-ний баг тамирчид

оролцож, "НИК" ХХК-ний баг тамирчид тодорч "Metrology-20" шилжин явах цомын эзэн боллоо. Спортын 2 төрөлт тэмцээнд "Тэс Петролиум" ХХК-ий баг тамирчид тэргүүлсэн.

Мандал сумын "Аз зурай" ХХК-ий "Гоё машин" авто үйлчилгээ-авто засвар, "МТЭ" ХХК-ий "Буян-Ж" авто үйлчилгээ-авто засвар, "Формула" авто засварын газруудад "Авто үйлчилгээ-Ангилал. Ерөнхий шаардлага MNS 5025:2010", "Авто машины угаалгын үйлчилгээ. Ангилал, ерөнхий шаардлага MNS 5347:2003" стандартын дагуу тохирлын үнэлгээ хийж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэнд мэргэжлийн байгууллагуудын улсын байцаагч нар хяналт шалгалт хийж, зохих мэргэжил арга зүйн зөвлөмжөөр хангаж ажиллалаа.

Тайлант сард Сүхбаатар, Алтанбулаг, Түшиг, Шаамар сум, Сайхан, Мандал сумдын 18 аж ахуйн нэгж, иргэний 5 хүнсний дэлгүүр, 2 минимаркет, 1 хүнсний мухлаг, 4 зоогийн газар, 1 баар, 1 гэр буудал, 1 жуулчны бааз, 2 зочид буудал, 1 авто засварын үйлчилгээнд тохирлын үнэлгээ хийж, холбогдох стандартын шаардлага хангасан 17 үйлчилгээний газарт тохирлын гэрчилгээг 1-2 жилийн хугацаатай олголоо.

Аймгийн усан спорт, сургалтын төвийн барилга байгууламж, дотоод хяналтын лабораторийн үйл ажиллагаатай танилцаж, "Усан спортын төвийн орчин болон сургалтанд тавих шаардлага MNS 6559:2015" стандартын шаардлагын дагуу тохирлын үнэлгээ хийж, стандартын шаардлага хангаж сайжруулах зөвлөмжийг аймгийн Биеийн тамир спортын газарт хүргүүлсэн.

Стандартын салбар сангаас 13 аж ахуйн нэгж, байгууллага иргэний 7 нэрийн стандартын захиалгыг авч, 5 аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд 3 нэрийн стандартаар борлуулалт хийж, арга зүйн зөвлөгөө, үйлчилгээ үзүүлсэн.

Мөн ээлжит баталгаажуулалтаар худалдаа үйлчилгээний газрын 5 жинг баталгаажуулж, Сүхбаатар сумын айл өрхийн 14 ш цахилгааны 1 фазын тоолуур шалган ээлжит бус баталгаажуулалтанд хамруулсан.

Онцгой байдлын газрын ажил үйлчилгээний талаар:

Хуурайшилтын зэрэг нэмэгдэж ой, хээрийн түймэр гарах эрсдэл өндөр байгаатай холбогдуулан урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор сумдын Засаг дарга холбогдох газруудад 2 удаа зөвлөмж хүргүүлж, иргэд олон нийтэд гамшгийн аюулаас урьдчилан сэргийлэх мэдлэг мэдээлэл, сэрэмжлүүлэг хүргэх зорилгоор "Онцгой байдлын цаг" нэвтрүүлгийн 12, 13 дахь дугаарыг бэлтгэн орон нутгийн "Миний Монгол Тв"-ээр нэвтрүүллээ.

Сүхбаатар, Шаамар сумдад үйл ажиллагаа явуулдаг шатахуун түгээх станцын эрхлэгч, түгээгч нарын гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх мэдлэг, чадварыг дээшлүүлэх, шатахуун түгээх станцын галын аюулгүй байдлын норм дүрэм, шатахуунаар хангах мэргэжлийн ангийн үүрэг зохион байгуулалт, түлэгдсэн, бэртсэн үед үзүүлэх анхны тусламж сэдвүүдээр танхимын сургалтыг зохион байгуулж нийт 6 байгууллагын 34 ажилтанг хамруулсан. Мөн Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн Сэлэнгэ салбарын 14 ажилтан албан хаагчдад гамшиг, аюулт үзэгдэл, эмзэг байдал чадавхи, гал түймрийн тухай ойлголт, эмнэлгийн анхны тусламж боолт хийх арга сэдвүүдээр танхимын сургалтыг хийсэн.

"Гамшгийн эрсдэлийг олон нийтийн оролцоотой бууруулах үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх хүрээнд иргэд, олон нийтэд гамшгаас хамгаалах мэдлэг, хандлага, чадвар олгох зорилгоор Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Улсын тэргүүний 4 дүгээр сургуулийн 210 сурагчдад "Хэн ч, Хэзээ ч, Хаана ч Бэлэн" гамшгаас хамгаалах буухиа тэмцээнийг 2018 оны 06 дугаар сарын 04-ний өдөр сургуулийн биеийн тамирын задгай талбайд зохион байгууллаа. Тэмцээнд түрүүлсэн сурагчдыг "Аюулгүй өрх" зөвлөмжийн номоор урамшууллаа. Тэмцээний дараа сурагчдад гол, усны аюулаас урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл хийж, сэрэмжлүүлгийн материал тараан ажиллалаа.

“Зочид буудал аялал жуулчлал, амралт сувилал болон хүүхдийн зуслан”-ийн байгууллагуудад гамшгаас хамгаалах болон галын аюулгүй байдлын тухай хууль, дүрэм, норм, стандартын хэрэгжилтийг шалгах төлөвлөгөөт шалгалтын удирдамж”-ийн дагуу 85 объект, аж ахуйн нэгж, байгууллагуудад гамшгаас урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж, 158 зөрчил илрүүлж, 68 зөрчлийг хяналт шалгалтын явцад арилгуулан бусад зөрчлийг арилгуулахаар гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн заавал биелүүлэх албан шаардлага 51, мэдэгдэл 24 хууль тогтоомж, дүрэм, журам зөрчсөн, гамшгаас хамгаалах улсын хяналтын байцаагчийн шаардлагыг хэрэгжүүлээгүй 4 иргэнийг 400000 төгрөгөөр, торгож захиргааны арга хэмжээ ногдуулсан.

Гамшгаас урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын ажлын үзүүлэлтийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад хяналт шалгалтад хамрагдсан аж ахуйн нэгж, байгууллагын тоо 37.6 хувиар, зөрчил дутагдлыг арилгахаар бичсэн албан шаардлага 29.6 хувиар, мэдэгдэл 70 хувиар, хууль тогтоомж зөрчиж захиргааны арга хэмжээ авагдсан байдал 50 хувиар тус тус өссөн.

2018 оны 06 дугаар сард 8 удаагийн объектын гал түймэр гарсанаас мэдээллээр 2 гал түймрийг иргэд унтраан, 6 гал түймэр дээр гал түймэр унтраах, аврах анги ажиллаж унтрааж, 8 гал түймрийн хэргийг Цагдаагийн байгууллагатай хамтран шалгаж, гал түймэр гарсан тухай акт 8 үйлдэж шийдвэрлэж, 4 зөрчилд зөрчлийн тэмдэглэл үйлдэж материалыг хаасан бөгөөд 1 гал түймрийн хэрэг мөрдөн байцаалтын шатанд шалгагдаж байна.

Орон нутгийн ус, цаг уур, орчны шинжилгээний албанаас цаг агаарын нарийвчилсан мэдээллийг авч цасан болон шороон шуурганаас урьдчилан сэргийлэх талаар факс мэдээ 2-ыг сум орон нутаг, иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад хүргүүлсэнээс гадна болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх, цаг үеийн нөхцөл байдалтай уялдуулан сэрэмжлүүлэх мэдээ, мэдээллийг орон нутгийн кабелийн телевизээр 1, сонинд 4 удаа мэдээ явуулсан.

Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:

2018 оны 06 дугаар сарын 06-07-ны өдрүүдэд Санхүүгийн албаны дарга, төрийн сангийн мэргэжилтэн, нягтлан бодогч, нийт 109 ажилтнуудад “Төсөв, санхүүгийн үйл ажиллагааг дээшлүүлэх нь” сэдэвт 2 өдрийн сургалтыг зохион байгуулж, 2017 оны аудитын дүн, цаашид анхаарах асуудлууд, Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт, 2017 оны дүгнэлт, санхүүгийн тайлангийн нэгтгэлд гарсан алдаа, цаашид анхаарах асуудлууд, ТЗШ-ийн байгууллагуудын санхүүгийн талаар баримталж буй бодлого чиглэлийн тухай мэдээлэл өгч, Улсын секторын нягтлан бодогчдын институтын захирал, Монгол Улсын гавъяат эдийн засагч, доктор, профессор Р.Батжаргал багш Санхүүгийн тайлангийн зорилгоор хөрөнгө, өмчлөх эрхийг үнэлэх, Нягтлан бодох бүртгэлийн болон Аудитын тухай хуулиудыг хэрэгжүүлэхэд нягтлан бодогчийн үүрэг, хариуцлага, аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулах арга зүйн мэдээллийг өглөө. Мөн энэ сарын 14-15-ны өдрүүдэд Сангийн яамнаас Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Орон нутгийн төсөв, санхүүгийн удирдлагыг сайжруулах” семинарт Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтнүүд, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн хөрөнгө оруулалт хариуцсан мэргэжилтэн, сумдын Санхүүгийн албаны ажилтнууд болон Орон нутгийн хөгжлийн сан хариуцсан ажилтнууд хамрагдлаа.

1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

5-р сарын байдлаар

| Д/д | Үзүүлэлтүүд | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь |
|------------|--|---------------------|---------------------|--------------|
| | 1. Орон нутгийн төсвийн нийт орлого | 34,899,864,7 | 36,966,486,8 | 105,9 |
| 1.1 | Орон нутгийн төсвийн орлого | 6,988,640,8 | 6,846,325,9 | 98,0 |
| | Үүнээс: Аймгийн төсвийн орлого | 5,066,239,2 | 4,804,771,8 | 94,8 |

| | | | | |
|---|---|---------------------|---------------------|--------------|
| | Сумдын төсвийн орлого | 1,922,401,6 | 2,041,554,1 | 106,2 |
| 1.2 | Улсын төсвөөс олгох санхүүгийн дэмжлэг | 3,100,000,0 | 3,100,000,0 | 100,0 |
| 1.3 | Улсын төсвөөс олгох тусгай зориулалтын шилжүүлэг | 21,950,770,3 | 21,950,770,3 | 100,0 |
| 1.4 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг | 20,34,613,9 | 2,003,504,4 | 98,5 |
| 1.5 | Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/ | 673,420,6 | 2,761,970,3 | 410,1 |
| 1.6 | Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/ | 152,419,1 | 303,915,8 | 199,4 |
| 2. Орон нутгийн төсвийн нийт зарлага | | 39.840.281.4 | 29.584.484.9 | 74.3 |
| 2.1 | Орон нутгийн төсвийн нийт зарлага | 39.840.281.4 | 29.584.484.9 | 74.3 |
| | Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага | 7.618.324.5 | 2.859.037.1 | 50.7 |
| | Сумдын орон нутгийн хөгжлийн сан | 1.827.811.4 | 250.712.8 | 13.7 |
| | Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага | 8.429.346.3 | 5.793.304.8 | 68.7 |
| | Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт | 1.610.510.0 | 349.682.2 | 21.7 |
| | Аймгийн замын сангийн хөрөнгө оруулалт | 240.000.0 | 128.098.9 | 53.4 |
| | Аймгийн орон нутгийн хөгжлийн сан | 856.308.2 | 357.900.1 | 41.8 |
| | Халамжийн сан | 3.692.659.1 | 3.341.455.2 | 90.5 |
| | Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага | 1.873.569.0 | 1.482.747.0 | 79.1 |
| | Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө | 156.300.0 | 133.421.4 | 85.4 |
| | Сумдын тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага | 20.659.642.4 | 18.502.060.7 | 89.6 |
| | Аймгийн тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын зарлага | 1.305.156.8 | 1.179.369.5 | 90.4 |
| 3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг | | 26.026.364.3 | 25.941.195.9 | 99.7 |
| 3.1 | Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг | 2.040.980.1 | 1.986.921.2 | 97.4 |
| 3.2 | Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг | 1.501.363.8 | 1.470.254.2 | 97.9 |
| | Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд | 54.720.5 | 54.720.5 | 100.0 |
| | Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд | 162.004.2 | 162.004.2 | 100.0 |
| | Хөрөнгө оруулалтын зардалд | 1.284.639.1 | 1.253.529.5 | 97.6 |
| 3.3 | Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг | 533.250.1 | 533.250.2 | 100.0 |
| | Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд | 531.614.2 | 531.614.3 | 100.0 |
| | Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд | 1.635.9 | 1.635.9 | 100.0 |
| 3.4 | Сумдад олгосон тусгай зориулалтын шилжүүлэг | 20.627.288.2 | 20.627.288.2 | 100.0 |
| 3.5 | Аймагт олгосон тусгай зориулалтын шилжүүлэг | 1.323.482.1 | 1.323.482.1 | 100.0 |
| 3.6 | Тусгай зориулалтын шилжүүлэг /салбараар/ | 21.950.770.3 | 21.950.770.3 | 100.0 |
| | - Ерөнхий боловсролын сургууль | 11.229.697.1 | 11.229.697.1 | 100.0 |
| | - Хүүхдийн цэцэрлэг | 5.781.054.0 | 5.781.054.0 | 100.0 |
| | - Соёлын байгууллага | 1.439.416.9 | 1.439.416.9 | 100.0 |
| | - Биеийн тамир спортын байгууллага | 570.247.1 | 570.247.1 | 100.0 |
| | - Эрүүл мэндийн байгууллага | 2.586.604.0 | 2.586.604.0 | 100.0 |
| | - Газрын кадастрын байгууллага | 171.687.9 | 171.687.9 | 100.0 |
| | - Хүүхдийн байгууллага | 172.063.3 | 172.063.3 | 100.0 |
| 4. Тусгай сангуудын зарлага | | 784.306.3 | 57.417.2 | 7.3 |
| 4.1 | Сумдын сум хөгжүүлэх сан | 784.306.3 | 57.417.2 | 7.3 |

2.Өргөн хэрэглээний барааны үнэ ханшийн тухай:

| Өргөн хэрэглээний барааны нэр төрөл | 2018 V - сар | 2018 VI- сар | <u>2018- V</u> <u>2018-VI</u> /төгрөгөөр |
|--|-----------------|-----------------|--|
| 1.ХҮНСНИЙ БАРАА | | | |
| 1 ТАЛХ, ГУРИЛ, БУДАА | | | |
| Гурил /савласан, кг/ | 1 100 | 1 100 | 100.0 |
| Талх /орон нутгийн, ш/ | 1 100 | 1 100 | 100.0 |
| Нарийн боов /кг/ | 2 500 | 2 500 | 100.0 |
| Будаа /кг/ | 2 400 | 2 400 | 100.0 |
| Элсэн чихэр /кг/ | 2 200 | 2 200 | 100.0 |
| 2 МАХ, МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН | | | |
| Хонины мах /кг/ | 6 000 | 6 000 | 100.0 |
| Үхрийн мах /кг/ | 7 500 | 7 500 | 100.0 |
| Адууны мах /кг/ | 5 500 | 5 800 | 105.5 |
| Ямааны мах /кг/ | 5 000 | 5 500 | 110.0 |
| Дотор мах, цувдай /цусгүй/ | 3 500 | 3 500 | 100.0 |
| Хиам /чанасан, кг/ | 10 000 | 10 000 | 100.0 |
| 3 СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ | | | |
| Сүү /задгай, л/ | 1 500 | 1 500 | 100.0 |
| Сүү / савласан, л/ | 2 600 | 2 600 | 100.0 |
| Тараг /задгай, л/ | 1 800 | 1 800 | 100.0 |
| Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/ | 12 000 | 12 000 | 100.0 |
| Айраг /л/ | 3 500 | 3 500 | 100.0 |
| Хуурай сүү /кг, Орос, 25% тослогтой/ | 4 500 | 4 500 | 100.0 |
| Өндөг /ш/ | 350 | 350 | 100.0 |
| 4 БҮХ ТӨРЛИЙН ӨӨХ ТОС | | | |
| Ургамлын тос /л/ | 3 800 | 3 800 | 100.0 |
| Өөхөн тос /кг/ | 1 500 | 1 500 | 100.0 |
| Шар тос /кг/ | 15 000 | 15 000 | 100.0 |
| Масло /задгай, кг/ | 4 500 | 4 500 | 100.0 |
| 5 ХҮНСНИЙ НОГОО | | | |
| Төмс /кг/ | 1 200 | 1 200 | 100.0 |
| Лууван /кг/ | 1 200 | 1 200 | 100.0 |
| Манжин /кг/ | 1 500 | 1 500 | 100.0 |
| Байцаа /кг/ | 1 500 | 1 500 | 100.0 |
| Сонгино /кг/ | 1 500 | 1 500 | 100.0 |
| Өргөст хэмх /шилтэй, дарсан/ | 3 500 | 3 500 | 100.0 |
| Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/ | 2 300 | 2 300 | 100.0 |
| 7 ШАТАХУУН | | | |
| Бензин А - 80 | 1 580 | 1 530 | 96.8 |
| Бензин А - 92 | 1 735 | 1 735 | 100.0 |
| Дизелийн түлш | 2 020 | 2 020 | 100.0 |

Гурав.Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:

2018 оны 06 дугаар сарын 26-ны өдөр Дэлхийн хар тамхи, мансууралтай тэмцэх олон Улсын өдрийг тохиолдуулан Алтанбулаг сумын хилийн боомтоор Улсын хил нэвтэрч буй иргэдэд хар тамхи, мансууруулах бодисын эсрэг ухуулга, сурталчилгаа хийх, төрийн байгууллагын албан хаагч нарт сургалт зохион байгуулах, харилцан мэдээлэл солилцох, хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлах, тархац устгалын үйл ажиллагаанд хяналт тавих зорилго бүхий

өдөрлөгийг Хууль зүй дотоод хэргийн яам, Цагдаагийн ерөнхий газар, Гаалийн ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, Гадаадын иргэн, харьяатын газар, Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв хамтран зохион байгууллаа.

2018 оны эхний 5 сарын байдлаар 194 холбогдогчтой, 421.3 сая төгрөгийн хохиролтой, 298 гэмт хэрэг бүртгэгдэж, 9 хэргээр буюу 3.1 хувиар урьд оны мөн үеэс өсч, гэмт хэргийн илрүүлэлт 38.8 хувьтай байна. 5 дугаар сарын байдлаар 8304 зөрчлийг илрүүлэн шалгаж шийдвэрлэсэн нь 2483 зөрчлөөр буюу урьд оны мөн үеэс 23.0 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Эрх зүйн албан бус сургалт сурталчилгааны ажлын хүрээнд “Захиргааны ерөнхий хууль”, “Зөрчлийн тухай” хууль, “Галын аюулгүй байдлын тухай хууль”, “Хүүхдийн эрхийн тухай”, “Хүүхэд хамлааллын тухай”, “Гэр бүлийн хүчирхийллийн тухай” “Гэр бүлийн тухай” хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Татварын ерөнхий хууль, зэрэг сэдвүүдээр 2018 оны эхний хагас жилийн байдлаар аймгийн хэмжээнд давхардсан тоогоор 26340 гаруй иргэд, төрийн албан хаагчдад хууль, эрх зүйн албан болон албан бус сургалтан зохион байгуулж, сум, агентлаг, байгууллагуудад 1500 гаруй хуулийн эмхтгэл, гарын авлага материалаар хангаж ажиллалаа.

2018 оны эхний хагас жилийн байдлаар газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн гэрчилгээ 341 бичиж, лавлагаа 5 олгож үйлчилж, аймгийн хэмжээнд төрсний бүртгэл 1152, гэрлэлтийн бүртгэл 259, гэрлэлт цуцалсны бүртгэл 104, эцэг тогтоолт 57, овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл 50, нас баралт 308 бүртгэж, иргэний үнэмлэх 3485 иргэнд дахин болон шинээр, гадаад паспорт 623 иргэнд олгож, аймаг хот руу бүр мөсөн шилжин явсан 2051, аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн 1427, хот доторх шилжилт хөдөлгөөн 4838 тус тус хийсэн байна.

Дөрөв.Нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд:

1.Боловсрол, соёл урлаг, спортын чиглэлээр:

2017-2018 оны хичээлийн жилд 5, 9, 12 дугаар анги төгсөгчдөөс авах Улсын шалгалтыг “ЕБС-ийн суралцагчийн болон боловсролын чанарын үнэлгээний журам”-ын дагуу 2018 оны 05 дугаар сарын 28-наас 06 дугаар сарын 08-ны өдрүүдэд зохион байгуулсан. 2017-2018 оны хичээлийн жилд төрийн өмчийн 33, хувийн хэвшлийн 1, нийт 34 ерөнхий боловсролын сургуулийн 5 дугаар ангийг 1725 сурагч, 9 дүгээр ангийг өдрөөр 1567 сурагч, дүйцсэн хөтөлбөрөөр 67 сурагч, 12 дугаар ангийг өдрөөр 1409 сурагч, дүйцсэн хөтөлбөрөөр 77 сурагч төгсөж, гэрчилгээ, үнэмлэхийг олгосон.

5 дугаар анги төгсөж байгаа сурагчдын Улсын шалгалтын дүнг нийт даалгаврын гүйцэтгэл болон онц, сайн дүнгийн үзүүлэлтээр сүүлийн 5 жилээр нь гаргаж, өмнөх жилтэй харьцуулахад монгол хэлний хичээлийн шалгалтын гүйцэтгэл 4,8 хувь, математик 0,8 хувь, хүн ба байгаль хичээлийн шалгалтын гүйцэтгэл 4,6 хувь, нийт дүнгээр бага боловсролын улсын шалгалтын гүйцэтгэл 76,3 хувьтай бөгөөд 3,3 хувийн ахицтай үнэлэгдсэн.

Элсэлтийн ерөнхий шалгалтыг Сүхбаатар сумын 1 дүгээр сургуульд зохион байгууллаа. Элсэлтийн ерөнхий шалгалтанд: Монгол хэл бичиг 1511 шалгуулагч орохоос 1448 ирж, ирээгүй 63, Физик-644 шалгуулагч орохоос 623, ирээгүй 21, Монгол улсын түүх- 53 шалгуулагч орохоос 51, ирээгүй 2, англи хэл-984 шалгуулагч орохоос 957, ирээгүй 27, газар зүй-44 шалгуулагч орохоос 44, биологи-210 шалгуулагч орохоос 207, ирээгүй 3, математик-1232 шалгуулагч орохоос 1200, ирээгүй 32, монгол хэл-814 шалгуулагч орохоос 781, ирээгүй 33, нийгмийн тухай мэдлэг-1106 шалгуулагч орохоос 1069, ирээгүй 37, хими-200 шалгуулагч орохоос 193, ирээгүй 7, орос хэл-58 шалгуулагч орохоос 56, ирээгүй 2 шалгуулагч оролцсон.

Үндэсний сурын аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж, 30 гаруй харваачид, Монгол улсын дархан мэргэн харваач 1, Монгол улсын мэргэн 1, спортын мастер 3, спортын дэд мастер 2 цэц мэргэн оролцсон.

Монголын Үндэсний Пара хөнгөн атлетикийн холбооны Улсын аварга шалгаруулах тэмцээнийг 2018 оны 06-р сарын 09-10 өдрүүдэд аймгийн төв цэнгэлдэх хүрээлэнд зохион байгуулж Сэлэнгэ, Хөвсгөл, Орхон, Архангай, Төв, Говь алтай, Дархан-Уул, Дорнод, Өвөрхангай, Булган, Өмнөговь, Сүхбаатар, аймгууд болон Улаанбаатар хотын Налайх, Баянгол, Баянзүрх, Чингэлтэй дүүргийн нийт 250 гаруй тамирчид, шүүгчид, дасгалжуулагчид, аймгуудын нийгмийн халамж үйлчилгээний хэлтсийн удирдлагууд болон албаны хүмүүс оролцсон. Мөн “Биеийн тамир, спортын эрх зүйн шинэчлэл-тогтвортой хөгжил” сэдэвт төвийн бүсийн сургалт, зөвлөгөөнийг 2018 оны 06-р сарын 11,12-нд зохион байгуулсан. Зөвлөгөөнд Дархан-Уул, Өмнөговь, Дундговь, Төв, Сэлэнгэ аймгийн БТСГ-ын дарга, биеийн тамирын асуудал хариуцсан мэргэжилтэн, дасгалжуулагч, арга зүйч, Ерөнхий боловсролын сургуулийн биеийн тамирын багш нийт 67 хүн оролцсон.

2.Эрүүл мэндийн талаар:

Эрүүл мэндийн яам, Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтран Цагааннуур, Шаамар, Хүдэр, Ерөө, Жавхлант, Хушаат, Алтанбулаг сум, Бугант тосгоны 8 эрүүл мэндийн төвийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний байдалд хөндлөнгийн хяналт үнэлгээг хийлээ. Жил бүр уламжлал болгон тэмдэглэдэг цусны донорын өдрийг “Цусаа өгч бусдад амьдрал бэлэглэе” уриатайгаар аймгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлж, хүндэт донор, тогтмол хугацаанд цусаа бэлэглэгч доноруудыг олон нийтэд таниулах, тэдэнд талархал илэрхийлэх, алдаршуулах ажлыг хийж, нийт 300-аад хүнийг хамруулсан.

Эх хүүхдийн эрүүл мэндийн төв, Швейцарын хүүхдийн хэт авиан оношилгооны нийгэмлэгийн эмч нартай хамтран “Нярайн түнхний үений дутуу хөгжил, мултралыг хэт авиагаар эрт оношлох, мултралаас сэргийлэх эмчилгээ” сэдэвт сургалтыг Дархан-Уул, Өвөрхангай, Архангай, Булган, Орхон, Сэлэнгэ аймгийн Нэгдсэн эмнэлгүүдийн дүрс оношилгоо, нярай, эх барих эмэгтэйчүүдийн эмч нарын 24 хүн хамрагдсан. Аймгийн нэгдсэн эмнэлэг, Мандал Нэгдсэн эмнэлэгт шинээр төрсөн 158 нярайг түнхний эход харж, түнхний үений дутуу хөгжилтэй байх магадалтай 15 хүүхдийг товлолт хугацаанд дахин хянахаар боллоо.

Батлан хамгаалах яам, аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штабтай хамтран “Цэргийн насны залуусын эрүүл мэндийн асуудалд тулгарч буй бэрхшээл, түүнийг даван туулах арга зам, цэрэг татлагын эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулах тухай” сургалтыг зохион байгуулж, эрүүл мэндийн байгууллагын удирдах ажилтан, эмч нарын 40 хүнийг хамруулсан.

Мандал суманд шинээр тусгай зөвшөөрөл хүссэн 3, Баянгол сумын 1 эмийн санд тус тус шинжээчийн баг ажиллаж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгсөн.

Ерөө сумын 15-аас дээш насны иргэдийг эрүүл мэндийн мэдээллийн цахим санд бүртгэж Халдварт болон халдварт бус өвчний цогц үзлэг оношлогоог 13 төрлийн нарийн мэргэжлийн эмч нар, 8 төрлийн оношлогоо шинжилгээг хийж үзлэгт Ерөө сумын хамрагдвал зохих иргэдийн 80,2 хувь нь хамрагдаж өвчтэй илрэгсдийг эмчилгээ хяналтанд авч, эрүүлжүүлэх төлөвлөгөө боловсруулан ажиллаж байна.

3.Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн талаар:

Аймгийн Прокурорын газрын ерөнхий прокурор, хууль цаазын шадар зөвлөх Ж.Мөнхжаргалаар ахлуулсан ажлын хэсэг Сайхан суманд, Боловсрол, соёл, урлагийн газрын дарга Ч.Жаргалсайхан ахлагчтай баг Мандал суманд, ИТХ-ын нарийн бичгийн дарга Э. Оюунболдын ахалсан ажлын хэсэг Зүүнбүрэн суманд тус тус ажиллаж Хүүхдийн эрхийн хууль зүйн хороотой танилцахаас гадна гишүүд өөр өөрсдийн чиглэлээр хорооны гишүүдэд зөвлөн тусалж ерөнхий боловсролын дунд, ахлах ангийн сурагчдад хууль эрх зүйн чиглэлээр сургалт нөлөөллийн ажлыг зохион байгуулж, 450 гаруй хүүхдүүдийг хамрууллаа.

-“Цахим орчин дахь хүүхэд хамгаалал” сэдэвт нийтлэл, нэвтрүүлгийн уралдааны удирдамжийг 17 суманд хүргүүлсэн боловч одоогоор иргэд материалаа ирүүлээгүй байна.

Олон Улсын Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг “Хүүхэд гэр бүлдээ жаргалтай” уриан дор тэмдэглэн өнгөрүүлж, төв талбай дээр аяга өрөлт, зургийн уралдаан, цагираг тоглох зэрэг арга хэмжээнүүдийг багтаасан “Хүүхэд гэр бүлдээ жаргалтай” тоглоомын өртөө, хүүхдийн спортын ролёк, дугуйн уралдаануудыг тус тус зохион байгуулж үйлчлүүлсэн хүүхдүүдийг зайрмагаар урамшууллаа. 17 сум 6 тосгоны 56 багт оршин суугаа хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаанд байгаа 398 хүүхэд, зорилтод бүлгийн 202 хүүхдүүдэд баярын бэлэг хүргүүлсэн. Сүхбаатар сумын Засаг даргын Тамгын газартай хамтран “Халамж” нэгдсэн арга хэмжээг зохион байгуулан зорилтод бүлгийн 300 хүүхдийг эмчийн үзлэгт хамруулж, халамжийн үйлчилгээ үзүүлж, тусгай хүндэтгэлийн арга хэмжээнд оролцуулан, баярын бэлэг гардуулсан.

“Хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга” сургалтын нээлтийг Олон Улсын Худалдааны төвд зохион байгуулж 100 гаруй иргэд, олон нийтэд мэдээлэл, сурталчилгаа хийсэн.

“Тамхины эсрэг дэлхийн өдөр”-ийг тохиолдуулан байгууллагын албан хаагчдад “Тамхины ишгүй байгууллага” өдөрлөг, “Тамхи-Монголын шинэ үеийн сонголт биш”, “Архи, тамхины хор хөнөөл ба түүний талаарх түгээмэл буруу ойлголтууд” зэрэг мэдээлэл хийж нийт 19 албан хаагч оролцсон.

“Оролцоод хөгжье” хүүхдийн оролцооны байгууллагын үндэсний чуулганд аймгаа төлөөлөн 10 хүүхдийг оролцуулсан.

Орон нутагт анхан шатны нэгж дээр ажиллаж буй хүүхэд, гэр бүл, залуучуудын асуудлаар үүрэг хүлээгчдийг мэдлэг мэдээллээр ханган, чадавхжуулах зорилгоор “Хүүхэд, гэр бүл, залуучуудын асуудлаар үүрэг хүлээгчдийн зөвлөгөөн”-ийг зохион байгуулсан. Зөвлөгөөнд 17 сум, 6 тосгоны Засаг дарга, хүүхдийн төлөө зөвлөлийн тэргүүн, нийгмийн бодлого хариуцсан мэргэжилтнүүд, Сүхбаатар, Сайхан, Мандал сумдын Хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүд нийт 80 гаруй хүн оролцсон.

Мандал сумын 10 хамтарсан багийн 50 гишүүдэд Дэлхийн зөн ОУБ-тай хамтран Хамтарсан багийн сургалт, “Хүүхдийн хөдөлмөр” сургалт, “Уралдаанч хүүхдийн аюулгүй байдал” хэлэлцүүлгийг тус тус зохион байгуулсан. Мөн “Хүүхдийн эрх ба бизнесийн зарчим” сургалтыг зохион байгуулж, нийт 80 хүн хамрагдаж, 11 сургагч багш бэлтгэгдсэн.

-Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн 60 оюутанд амьдрах ухааны боловсрол олгох сургалтыг “Өөртөө итгэх итгэл”, “Харилцаа”, “Сэтгэл хөдлөл” зэрэг сэдвүүдээр зохион байгууллаа. Өсвөр үе, залуучуудыг номтой нөхөрлүүлэх зорилгоор “Оюуны клуб”-ыг байгуулж, гишүүнчлэлийн карт нээсэн. Карттай болсноор номоо солилцох, өөрт байгаагаас илүү олон ном унших боломж бүрдсэн. Мөн Залуучуудын хөгжлийн төвд мэдээ мэдээллийн самбарыг байршуулж, сүүлийн үеийн ажлын байр, цаг үеийн мэдээ, хууль тогтоомжийн талаарах мэдээллийг авах боломжтой.

Өсвөр үе, хүүхэд багачуудын хувь хүний хөгжлийг дэмжих зорилгоор “Англи хэлийг хэрхэн хурдан сурах вэ?”, “Тэтгэлэгт хэрхэн хамрагдах вэ?” сургалтыг зохион байгуулж нийт 51 хүүхэд хамрагдсан.

4.Хөдөлмөр, нийгмийн халамжийн үйлчилгээний талаар:

2018 оны 05-р сарын байдлаар бүртгэлтэй ажилгүй иргэд 862 байсан бол 457 иргэн шинээр бүртгүүлж ажил олгогчоос ирүүлсэн 585 ажлын байранд 402 хүнийг ажилд зуучилж, идэвхигүйн улмаас 85 иргэн хасагдаж бүртгэлтэй ажилгүйчүүдийн тоо 832 болсон. Залуучуудын хөдөлмөр эрхлэлт, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд “Start up Weekend” сургалтын арга хэмжээг 30 иргэнийг оролцуулан сургалтын зардалд 1894,7 төгрөгийг зарцуулсан. Сургалтын үр дүнд үсчин, гар утас засвар, үхэр бордох, гагнуурчин зэрэг чиглэлээр 11 иргэнийг 5 бүлэг болгож эргэн төлөх нөхцөлтэйгээр 30785,0 мянган төгрөгийг зарцуулан 11 шинэ ажлын байр бий болгон ажиллаж байна.

Мэргэжил олгох сургалтын хүрээнд Цагааннуур, Мандал, Түшиг сумдын 54 иргэнийг тогооч, худалдагч мэргэжлүүдээр сургаж Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 8228,0 мянган төгрөгийг зарцуулсан. Мэргэжилтэй болсноор хөдөлмөрийн зах

зээлд өрсөлдөх чадвар дээшилсэн бөгөөд өөрөө өөртөө ажлын байр бий болгох нөхцлийг нь бүрдүүллээ.

“Халамжаас хөдөлмөр эрхлэлт рүү” өдөрлөгийг 2018 оны 06 дугаар сарын 14-ны өдөр Алтанбулаг суманд зохион байгуулж, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээний ганцаарчилсан зөвлөгөө авах үйлчилгээнд халамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа 56 иргэн, 20 төрийн албан хаагч хамрагдлаа.

Нийгмийн халамжийн сангаас 6 дугаар сарын байдлаар 36306 иргэнд 7,477,431,0 мянган төгрөгийн тэтгэвэр, тэтгэмжийг олгоод байна.

5.Нийгмийн даатгалын ажил үйлчилгээний талаар:

2018 оны эхний хагас жилд 12.4 тэрбум төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөтөйгээс 6-р сарын 24-ний байдлаар өссөн дүнгээр 12.5 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, 101.28 хувийн биелэлттэй байна.

Тэтгэврийн даатгалын сангаас 16172 тэтгэвэр авагчдад 25.4 тэрбум төгрөгийг тэтгэвэрт, тэтгэмжийн даатгалын сангаас 3021 хүнд 1157.32 сая төгрөгийг Хөдөлмөрийн чадвараа түр алдсан, жирэмсэн амаржсан, оршуулгын тэтгэмжид, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас үйлдвэрийн ослын тэтгэвэр, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны тэтгэмж, нөхөн төлбөр, сувиллын зардалд 245 хүнд 492.26 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас 218 хүнд 277.95 сая төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид тус тус олгосон. Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн лавлагааг тайлант сард 245 иргэд, даатгуулагчдад гаргаж үйлчиллээ.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоор 2018 оны 06 сард нийт 2 хурал хийж 135 хүнээс, 5 хүнийг цуцалж, 16 хүн шинээр тогтоолгосон, 114 хүн актаа сунгуулса. Төрийн банкны Сэлэнгэ салбартай хамтран ажиллах гэрээг байгуулж, 17 сум 6 тосгонд 27 удаагийн сургалт зохион байгуулж нийт 656 хүн хамрагдсан. Үүнээс 209 иргэнд сайн дурын даатгал, 59 иргэнд тэтгэврийн даатгал, 227 иргэнд гар утасны аппликейшн, 161 иргэнд тэтгэмжийн даатгал, ажилгүйдлийн даатгал, ҮОМШӨ-ний даатгал, эрүүл мэндийн даатгалын талаар зөвлөгөө өгсөн.

Тав.Үйлдвэр, хөдөө аж, ахуйн бодлогын хүрээнд:

“Хөдөө аж ахуйн органик үйлдвэрлэл эрхлэх болон органик хүнс үйлдвэрлэхэд баримтлах журам”-ыг сурталчлах сургалтыг аймгийн төвд зохион байгуулж, 17 сумын 130 газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч, 320 зөгийн аж ахуй эрхлэгчдийг оролцуулан зохион байгуулж, 770 гарын авлага бэлтгэн тарааж, сурталчлан ажилласан.“Монгол үйлдвэрлэв” үндэсний каталогид орох 3 аж ахуйн нэгжийн мэдээллийг ХХААХҮЯ-ны ЖДҮХС-нд хүргүүлсэн.

2018 онд нийт 724676 эх мал төллөхөөс 06 дугаар сарын 24-ний байдлаар нийт 562548 мал төллөж, үүнээс ингэ 61, гүү 15272, үнээ 49885, эм хонь 292984, эм ямаа 204346 төллөөд байна.Төлийн хорогдол 4526 үүнээс унага 99, тугал 536, хурга 1892, ишиг 1999 хорогдсон дүн мэдээтэй мал төлөлт 78 хувьтай байна. Том малын зүй бус хорогдол нийт 8126 үүнээс тэмээ 4, адуу 561, үхэр 1999, хонь 3122 ямаа 2648 үүнээс хээлтэгч мал нийт 2098 үүнээс гүү 92, үнээ 558, хонь 812, ямаа 636 хорогдож өвчнөөр нийт 358 мал үүнээс адуу 31, үхэр 100, хонь 107, ямаа 120 хорогдсон дүн мэдээтэй байна. “Малын генетик нөөцийн тухай хууль”, “Мал амьтны эрүүл мэндийн тухай хуулиуд” 06 дугаар сарын 01-н өдрөөс хэрэгжиж эхлэсэнтэй холбоотой танилцуулагыг Дархан, Эрдэнэт хотод 6 сарын 15,16нд болсон. Үүнд 15 сумын тамгийн газрын дарга, мэргэжилтэн малчдыг хамруулж зөвлөгөөндөө оролцуулан хийгдсэн.

Аймгийн хэмжээнд зуншлагын байдал Баруунбүрэн, Орхонтуул, Сант, Орхон, Сайхан Баянгол Мандал сумдаар хавар эрт ногоо гарсанч бороо орохгүй улмаас энэ 7 сум гандах төлөвтэй байна. Үлийн цагаан огтоно устгаж байгаа Сайхан, Сант, Орхон, сумд Хөдөө аж ахуйн газраас өгсөн 2 багжаар устгаж байна. Үүнд газар

цөмлөгч, уураар утагч, ус цутгаж устгаж байна. Сумдууд 2,3 баг гарган сумын газрын даамал байгаль хамгаалагч, багийн даргаараа ахлуулж ард иргэдтэйгээ хамтран ажиллаж байна.

Сүхбаатар, Алтанбулаг, Зүүнбүрэн, Шаамар зэрэг сумдаас ирсэн мал, амьтны халдварт өвчний сэжиг бүхий дуудлага бүрт шуурхай зөвлөгөө, зөвлөмжийг өгч, шуурхай хариу арга хэмжээг хэрэгжүүлж, Мөн төлөвлгөөт шинжилгээний дагуу Сайхан сум цөм сүрэг, Түшиг номтын өндөр Шаамар туяа сан зэрэг МЭҮН-үүд ирүүлсэн цусанд бруцеллөз өвчний шинжилгээг хийж халдваргүй болхыг тогтоон ажилласан.

Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дуут, цусан халдварт, томуу, гцхибалнад, зэрэг тарилгыг татан төвлүүлж сумдын МЭҮН-үүдэд хувиарийн дагуу тарааж вакцинжуулалтын ажил хэвийн явагдаж байна.

Гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгийг Цагааннуур, Орхонтуул, Баруунбүрэн, мөн эржимжсэн аж ахуйн үхэр, гахайг 100 хувь хамруулан ажилласан. цэцэг өвчний вакцин улсаас нийлүүлэгдээгүй байна.

Зургаа. Хөрөнгө оруулалт, газрын харилцааны хүрээнд:

2018 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 14 ажлын эрх шилжин ирсэн бөгөөд 5 ажлын гэрээ байгуулсан, 1 ажил үнэлгээ хийгдэж байгаа бөгөөд 6 ажлын тендер зарлагдсан, 2 ажлын зураг төсөв хийгдэж байна. Аймгийн Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 63 ажил батлагдаж үүнээс 23 ажлын зохион байгуулах эрхийг сумд болон газар, агентлагийн дарганарт шилжүүлсэн бөгөөд 11 ажлын гэрээ байгуулагдаж ажил явагдаж байгаа бөгөөд 4 ажил бүрэн дуусч 3 ажлыг хүлээлгэн өгөхөд бэлэн болсон, 9 ажлын тендер материал авах хугацаандаа 2 ажлын үнэлгээ хийгдэж байгаа бөгөөд 10 ажлын зураг төсөв бэлэн болсон ба орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 29 ажил батлагдснаас 8 ажлын зохион байгуулах эрхийг сумд болон агентлагт сум, газар, агентлагийн дарганарт шилжүүлсэн бөгөөд 13 ажлын гэрээ байгуулагдаж үүнээс 1 ажил бүрэн дууссан 7 ажил хүлээлгэн өгөхөд бэлэн болоод. 2 ажлын үнэлгээ хийгдэж 3 ажил материал авах шатандаа, Замын сангийн хөрөнгө оруулалтаар нийт 19 ажил батлагдсан бөгөөд 1 шилжих хөрөнгө оруулалтын ажил бүрэн санхүүжүүлж сумдад 18 ажлын эрх шилжүүлээд байна.

Хүдэр сумын АТП -1318 дэд Станцын 0.4кВ -ын ЦДАШ шинэчлэлтийн ажил, Сүхбаатар сум КТП-422 дэд станцын 0.4кВ-ын ЦДАШ -ын шинэчлэл, Баянгол сумын төвд 1.6 км бетон хучилттай авто замын төлөвлөх ажлын зураг төсвийг хянан баталгаажуулсан.

2018 оны 06 дугаар сарын 04-12-ны хооронд “Фотомониторингийн анхан шатны боловсруулалт, хиймэл дагуулын мэдээлэл ашиглан шинээр байгуулах цэгийг тодорхойлох” сэдэвт сургалтанд хамрагдсан бөгөөд 2018 оны 06 оны 25-ны өдөр газрын даамлуудад уг сургалтыг аймагтаа зохион байгуулсан.

Аймгийн хэмжээнд хагас жилийн байдлаар иргэн, аж ахуйн нэгж төрийн байгууллагад 589 хаягийн өөрчлөлт, 270 хаягийг шинээр газрын кадастрын мэдээллийн санд бүртгэн мэдээллээр үйлчилж ажилласан.

2018 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд 15 сумын нутаг дэвсгэрт дуудлага худалдааны зарчмаар эзэмшүүлэхээр тусгагдсан газраас 2018 оны 05 дугаар 20-ны байдлаар Алтанбулаг суманд 3 байршилд 8.5 га газарт дуудлага худалдааг цахим хэлбэрээр зохион байгуулсанаас үйлдвэрлэл үйлчилгээний зориулалттай 2 нэгж талбарын 3.5 га газрыг 8.9 сая төгрөг, Баянгол суманд танхимаар 14 дуудлага худалдааг зохион байгуулснаас худалдаа үйлчилгээний зориулалттай 3 нэгж талбарын 2.24 га газрыг 4.8 сая төгрөг дуудлага худалдааг зохион байгуулж орон нутгийн төсөвт 13.7 сая төгрөг төвлөрүүлэн ажилласан.

Долоо. Байгаль орчин, аялал жуулчлалын хүрээнд

2018 оны 6 дугаар сарын 2, 6, 11, 12, 14, 17-нд ихэнх сумдын нутгаар, 3-нд Ерөө, Бугант суманд, 5-нд Сүхбаатар, Баруунбүрэн, Түшиг суманд, 12-нд Сүхбаатар, Орхонтуул, Зүүнбүрэн, Бугант сумдад, 13-нд Сүхбаатар, Түшиг суманд, 16-нд

Орхонтуул, Мандал, Баруунбүрэн, Түшиг сумдын нутгаар, 18-нд Сүхбаатар, 20-нд Сүхбаатар, Түшиг суманд тус тус 0,0-1,0 мм бороо орлоо. Бусад хугацаанд бороо ороогүй. Ихэнх хугацаанд салхи баруун болон баруунаас 4-9 м/сек байв. 2, 6, 11, 12, 14, 17-нд нийт нутгаар салхи борооны өмнө түр зуур ширүүсч баруун өмнөөс 7-12 м/сек хүрсэн. 2018 оны 06 дугаар сарын 1-р арав хоногийн эхэн болон сүүлчээр, 2-р арав хоногийн эхээр өдөртөө агаарт 30-37 градус хүрч халсан. Бусад хугацаанд шөнөдөө 10-15 градус, өдөртөө 23-28 градус дулаан, хоёрдугаар 10 хоногийн байдлаар Сэлэнгэ аймгийн гол мөрний усны түвшин Сэлэнгэ мөрний усны түвшин Зүүнбүрэн сум орчмоор 230 см ОЖД-аас 1 см-ээр их, Сүхбаатар сум орчим 303 см ОЖД-аас 6 см-ээр их, Хүдэр голын усны түвшин Хүдэр сум орчмоор 220 см ОЖД-аас 4 см-ээр их байгаа бол Ерөө голын усны түвшин Ерөө орчмоор 284 см ОЖД-аас 8 см-ээр бага, Дулаанхан сум орчмоор 227 см ОЖД-аас 21 см-ээр бага, Орхон гол Сүхбаатар сум орчмоор 134 см ОЖД-аас 40 см-ээр бага, Орхон сум орчмоор 133 см ОЖД-аас 12 см-ээр бага, Хараа голын усны түвшин Баянгол сум орчмоор 151 см ОЖД-аас 15 см-ээр бага, Зэлтэр голын усны түвшин Түшиг сум орчмоор 244 см ОЖД-аас 6 см-ээр байна.

Зуншлагын байдал нутгийн 30 хувьд нь Түшиг, Цагааннуур, Ерөө, Хүдэр, Бугант, Жавхлант сумдын нутгаар хэвийн, 60 хувьд дунд, 10 орчим хувьд нь муу байна. Бэлчээрийн ургамлын өндөр 8-28 см, таримал ургамлын ургалтын байдал Орхонтуул суманд дунд бусад сумдын нутгаар сайн, ургамлын өндөр 14-30см байна. Ихэнх сумдын нутгаар бараан далавчит, тоонолжилт, барбины таршаа 1м²-т хүрээнд дунджаар 1-10 царцаа ажиглагдсан ба Мандал суманд хэт олшролтын хэмжээнд хүрсэн.

Ойн мэргэжлийн байгууллагын түвшин тогтоох үзлэгийг Хүдэр, Ерөө суманд үйл ажиллагаа явуулж буй 32 ойн мэргэжлийн байгууллагыг хамруулж, ойн санг гэрээгээр эзэмшигч 178 нөхөрлөлүүдийн үйл ажиллагаанд “тусгай” шалгуур үзүүлэлтээр үнэлэлт дүгнэлт өгөх түвшин тогтоох зорилгоор Мандал сумын Хэрх Дарьт Шаазгайт Тарни Түнх зэрэг газрын 27 нөхөрлөлийн 120 гишүүн, Алтанбулаг, Хүдэр, Ерөө сумын 31 нөхөрлөлийн 43 гишүүн нийтдээ 58 нөхөрлөлийн 163 гишүүд оролцлоо.

Аймгийн Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 04-ний А/214 тоот “Албадан буулгах, хөрөнгө гаргах тухай”, А/168 тоот “Ажлын хэсэг байгуулах тухай” захирамжуудын дагуу 2018 оны 06 дугаар сарын 05-ны өдрөөс 2018 оны 06 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл Сэлэнгэ аймгийн Ерөө сум Бугант тосгоны нутаг Хавчирганы ам, Хэрээн гол, Жаргалантын ам, Их алт, Бага ажир, Ялбаг гэх газруудад хууль бусаар ашигт малтмал олборлохоор бэлтгэсэн болон олборлолтын үйл ажиллагаа явуулсан иргэн аж ахуйн нэгж, байгууллага, нөхөрлөлүүдэд “Байгаль орчныг хамгаалах тухай хууль”, “Ашигт малтмалын тухай хууль”, “Газрын тухай хууль”-иуд болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан тогтоол, дүрэм, журмын хэрэгжилтэнд хяналт тавьж Зөрчлийн тухай хууль, Эрүүгийн хуулийн дагуу арга хэмжээг авч ажилласан.

Найм.Сум орон нутгийн талаар

Баруунбүрэн сум:

Энэ онд сумын хэмжээнд нийт 10751 га талбайд тариалалт хийснээс улаан буудай 9258, царгас 30, овъёос 5, тэжээлийн ургамал 190, арвай 8, рапс 1764, эрдэнэ шиш 90, гурвалжин будаа 45 га талбайд тариалсан бөгөөд төмс, хүнсний ногооны хувьд 90 га талбайд төмс, 76,1 га талбайд хүнсний ногоо тариалсан бөгөөд 11800 га талбайд уриншийн боловсруулалт хийхээр төлөвлөснөөс одоогоор 5 аж ахуй нэгж 2700 га талбайд уриншийн боловсруулалт хийгээд байна. Үр тарианы соёололтын үзлэгээр газрын даамал, БОХУБайцаагч нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 6-р сарын 14, 15-ны өдрүүдэд ажиллаж, тариалсан улаан буудайн соёололт 75-80%, гуурсанд тариалсан улаан буудайн соёололт 65-70%-тай байна.

Аймгийн статистикийн газар, Хүнс, хөдөө аж ахуйн газарт сар бүрийн эцэст том малын хорогдол мал төллөлтийн мэдээг гарган хүргүүлж байгаа бөгөөд сумын

хэмжээнд нийт 75429 толгой хээлтэгч мал төллөхөөс 58346 толгой хээлтэгч мал төллөж 58346 төл гарснаас 1910 төл хорогдож 56436 төл бойжиж байна.

Газрын тухай хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор Бургалтайн 2 дугаар багийн нутаг Өгөөмөр, Ганганы ам, Бөөрөнхий чулуут орчимд хаваржсан 20 өрхөд “Мэдэгдэх хуудас” хүргүүлэн, дурьдсан хугацаанд зусланд буугаагүй 2 иргэнд Зөрчлийн тухай хуулийн дагуу шийтгэл оногдуулан зөрчлийг арилгаад байна.

Улсын хэмжээнд зохион байгуулагдсан Ойн мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагааны түвшин тогтоох шалгалтанд Шинэ Орос хийц ХХК, Хэт жолоо ХХК зэрэг аж ахуйн нэгжийг бүрэн хамруулсан. “Шинэ-Орос Хийц” ХХК Бургалтайн 2 дугаар багийн нутаг уртын аманд 35 га талбайд нөхөн сэргээлтээр 15000 ширхэг шинэс, “Хэтжолоо” ХХК Ивэнгийн 1 дүгээр багийн Зүүвчийн аманд 7 га талбайд нөхөн сэргээлтээр 15000 ширхэг шинэсний 2 настай тарьцаар ойжуулалтын ажлыг хийж гүйцэтгэж комисст хүлээлгэн өгсөн.

Баянгол сум:

Сумын хэмжээнд энэ онд 7961,5 га-д үр тариа, үүнээс 274 га-д овъёос, 1609 га-д рапс, 5330 га-д улаан буудай, 29,5 га-д ногоон тэжээл, 717 га-д гурвалжин будаа, 2 га-д царгас тариалсан ба, 151,9 га-д төмс, хүнсний ногоон тариалсан байна. Төмс, хүнсний ногоо тариалагч м53 иргэн 76,5 га тариалангийн талбайн эргэн тойрныг хашаажуулсан.

2018 оны 6-р сарын 23-ны байдлаар мал төллөлт 64 хувьтай, том малын хорогдол 660 толгой, төлийн хорогдол 291 байна. Малд үзлэг ангилалтыг хуваарийн дагуу зохион байгуулж, 5300 бог малд үзлэг ангилалт хийлээ. Халдвартөвчнөөс урьдчилан сэргийлэх вакцины үлдэгдлийг татан авч, боом өвчнэий тарилгыг 25200 толгой малд хийж, бруцеллөз өвчнөөс урьдчилан сэргийлэх шинжилгээг эхлүүлээд байна.

Ой хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх зорилгоор Баян багийн Нарангийн ам гэх газарт хяналтын постыг ажиллуулж, тайлант хугацаанд 105 иргэн, 31 автомашиныг шалган сэрэмжлүүлэх хуудас тарааж, 5 аж ахуйн нэгж, байгууллагад ой хээрийн түймэр гаргахгүй байх талаар сэрэмжлүүлэг зөвлөгөө өглөө.

Нийгмийн халамжийн болон нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмжийг цаг хугацаанд нь тухай бүр олгож, Хөгжлийн бэрхшээлтэй иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 1, 35-аас дээш насаны иргэний ажлын байрыг дэмжих хөтөлбөрт 1, бүлгийн зохион байгуулалтаар хүнсний ногоо тариалах хөтөлбөрт 4 иргэнийг хамруулж, 6,0 сая төгрөгийн санхүүжилт олгож, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 2 ахмад настанг хамрууллаа.

Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлыг зохион байгуулж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2018 оны зарлигаар “Алдарт эх”-ийн одон авсан ээжүүдэд одонг гардуулж, сумын 3 үеийн ардын авъяатнуудын “Эх үрсийн элбэрэл” урлагийн тоглолт, “1000 бөмбөлөгийн баяр”, “Мөхөөлдөсний баяр”-ыг зохион байгуулснаас гадна сумын Соёлын төвийн дэргэдэх дугуйлангийн сурагчдын “Хүүхэд бүхэн жаргалтай байг” тайлан тоглолтыг зохион байгууллаа.

Аймгийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас зохион байгуулж буй “Нэг хүүхэд нэг байгууллага” аяны хүрээнд сумын төр төсвийн байгууллагуудад аяныг дэвтрийг аялуулж, 10 байгууллага зорилтот бүлгийн 16 хүүхдэд 1182,0 мянган төгрөгийн тусламж үзүүлсэн.

Монголын даамын холбоотой хамтран 100 буудалт даам сонирхогчдын улсын аварга шалгаруулах анхдугаар тэмцээнийг 6-р сарын 15-нд, “Сэлэнгэ бага хурд” бүсийн наадмыг 6-р сарын 17-ны өдөр тус тус зохион байгуулсан.

Ерөө сум:

Сумын Засаг даргын Тамгын газрын иргэний танхимд энэ сард 4 удаагийн сургалт, уулзалт хэлэлцүүлгийг зохион байгууллаа. Тухайлбал: Дархан-уул аймаг дахь ЖДҮДТөвөөс “Бизнесээ эхэл” төсөл бичих аргачлалын 3 өдрийн сертификаттай сургалтанд 21 иргэн, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний мэргэжилтэн, Нийгмийн

даатгалын байцаагч нар хамтран группын сунгалт, нийгмийн даатгалын шимтгэлийн 21 иргэнд, Ойн нөхөрлөлүүдийн үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх, түвшин тогтоох үнэлгээ хийх, Нутгийн иргэдэд түшиглэсэн аялал жуулчлалыг хөгжүүлэх нь сэдвээр аймгийн БОАЖГ-ын мэргэжилтнүүд сургалт хийж, 10 аж ахуйн нэгж, нөхөрлөлийн төлөөлөл, Сумын Засаг дарга алт хувиараа олборлох буй нөхөрлөлүүдтэй уулзалт хийж 34 иргэн хамрагдлаа.

Сумын хэмжээнд нийт 16179 толгой мал тооллогдсон бөгөөд төрлөөр нь авч үзвэл адуу 1257, үхэр 2515, хонь 6942, ямаа 5465, үүнээс 2018 онд шинээр 4868 төл /унага 208, тугал 490, хурга 2355, ишиг 1815./ гарсан байна. Малын хорогдол нийт 23 гарсан мэдээтэй байна.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны эрдэм шинжилгээний мэргэжилтэн, аймгийн Цөм сүргийн аж ахуйн мэргэжилтнүүд хамтран Ерөө үүлдрийн нарийн ноост хонь бүхий 3 өрхөөр орж ноосны дээж, ноосны гарцыг тодорхойлсон. Ноосны гарц нь 3-4.0 кг байна.

Сумын Засаг даргын захирамжаар байгуулагдсан ажлын хэсэг 6-р сарын 15-17-ны өдрүүдэд улаан буудай тариалсан 13822,4 га талбайд соёололтын үзлэг хийсэн бөгөөд сумын хэмжээнд нийт 23700 га эргэлтийн талбайтай. Энэ онд 14 аж ахуйн нэгж, 14 иргэн 15901,4 га-д үр тариа, тосны ургамал тариалсан.

Ерөө суманд суурилагдсан ТҮЦ машин 2018 оны 05-р сарын 25-аас 6-р сарын 25-нийг хүртэл нийт 152 иргэн үйлчилгээ авсан байна.

Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлж, Улсын тэргүүний Нарлаг цэцэрлэгийн авъяаслаг хүүхдүүд мэндчилгээ, хөгжимт гимнастик, ногоон гэрэл цагаан шугам уралдааны 2-р байрын шагналт хүүхэд багачуудын үзүүлэх тоглолт, ЕБС-ын 12 жилийн хүүхдүүд урлагийн тоглолт боллоо. Энэ үеэр Олон хүүхэд төрүүлж өсгөсөн нийт 12 алдарт эхчүүдэд одон гардуулах, Дархан бэрүүдийг алдаршуулан шагнаж урамшуулах зэрэг үйл ажиллагаа тус тус боллоо.

Жавхлант сум:

Сумын Засаг даргын Тамгын газар, төр төсвийн байгууллагуудын үйл ажиллагааг сайжруулах, ажлын хариуцлагыг дээшлүүлэх зорилгоор “Төрийн албан хаагчийн манлайлал ажлын байранд-2” 21 хоногийн аян, “Ёс зүйн зөрчилгүй хамт олон” аяныг тус тус зохион байгууллаа.

Сумын 1, 2 дугаар багийн иргэдийн нийтийн хурал, “Иргэдээ сонсьё” уулзалтыг багийн хөдөөгийн хэсэг болон сумын төвд зохион байгуулж, 1,2-р багийн Засаг даргын 2018 оны хагас жилийн тайлан, төр төсвийн байгууллагын дарга эрхлэгч нар хагас жилийн тайлангаа тавьж, сумын ИТхурлын дарга, Засаг дарга нар мэдээлэл хийж, 2019 оны орон нутаг хөгжлийн сангаар хийгдэх ажлын санал авч иргэдийн санал хүсэлтийг сонслоо. Хурлын үеэр Болд төмөр Ерөө голын удирдлагууд ирж мэдээлэл хийн зуны цэцэрлэгийн нээлтийг хийлээ. Мөн Бумбат 5 богд хоршоо мэдээлэл хийж ЭМТөв явуулийн амбулаториор үйлчилж ЕБСургуулийн авъяаслаг сурагчид тайлан тоглолт хийлээ. Ерөө голын орчимд зуны цэцэрлэг, багийн эмчийн байр барих ажлыг 13,0 сая төгрөгийн санхүүжилтийн санхүүжилтийг шийдвэрлэж өгөх саналыг “Болд Төмөр Ерөө гол” ХХК дэмжиж, санхүүжүүлэхээр боллоо.

УИХ-ын гишүүн Н. Оюундарийн санаачлага, дэмжлэгтэйгээр “Сум орон нутгийн хөгжилд иргэдийн оролцоо” өдөрлөг, мөн суманд үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчдийн 4,350,00 мянган төгрөгийн дэмжлэгээр “Хөх Чулуут хайрхан”-ыг тахиx арга хэмжээг тус тус зохион байгууллаа.

Аймгийн Засаг даргын А/230 тоот захирамжаар Жавхлант суманд 2018-2020 оны цэргийн дүйцүүлэх алба хаах 10 хоногийн дадлага сургалт зохион байгуулагдаж 40 иргэн хамрагдаж 2016-2018 онд Жавхлант сумаас цэргийн дүйцүүлэх алба хаасан 10 иргэн халагдаж "Цэргийн батлах"-аа гардан авлаа.

2018 оны 6-р сарын 19-ны байдлаар 14 аж ахуй нэгж, 4 иргэн нийт улаанбуудай 8287 га, рапс 1240 га, малын тэжээл царгас 5 га, эрдэнэшиш 11 га, 2 аж ахуй нэгж 53 иргэн төмс 53 га, хүнсний ногоо 106 га талбайд тариалалт хийгдэж дууслаа.

Хагас жилийн малын түүвэр судалгааг явуулж, 63 өрхийн 21928 мал тоологдсон.

2018 онд улс, аймаг, орон нутаг болон аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалт буюу Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй сургуулийн хичээлийн байр, дотуур байрны их засварын ажил, ахуй үйлчилгээний төвийн дулааны шугамын ажлууд эхэлсэн, “Болд төмөр Ерөө гол” ХХК-ний хөрөнгө оруулалтаар зуны цэцэрлэг, сумын төвийн төвлөрсөн хогийн цэгийг түрж булаах ажлууд хийгдэж дууссан.

Энэхүү ажилд цэргийн дүйцүүлэх албаны дадлага сургалтанд хамрагдаж байгаа 23 иргэн сумын төвөөс Олон улсын зам хүртэлх 7.3 км замын дагуух хог хаягдал, Шарын голын гүүрний тохой орчмын газрын хог хаягдлыг цэвэрлэж нийт 3.0 тн ахуйн хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт буулгав.

Эх үрсийн баярыг “Хүүхэд гэр бүлдээ жаргалтай” уриан тэмдэглэн өнгөрүүлж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар “Алдарт эхийн одон”-оор шагнагдсан 2 иргэнд гардуулж, “Хүслээр жигүүрлэсэн хүүхэд нас” цэцэрлэгийн хүүхдүүдийн тайлан тоглолт, “Хөх яргуй” дууны уралдаан, “Хүүхдийн баяр-Миний баяр” сэдэвт гар зургийн уралдаан, Дугайн уралдаан зэрэг уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулсан. Мөн ЗДТГазар, Сургууль, “Баянжаргалан хайрхан” ХХК, “Таваняргайт” ХХК, “Бүтээлч хүү” ХХК, Бумбат 1-р багийн иргэн Д.Цэвэгжав, Д.Энхтуяа нар урлаг, спорт, сурлагын амжилт гаргасан хүүхдүүд болон зорилтот бүлгийн 107 хүүхдэд бэлэг гардуулсан байна.

Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр хэрэгжиж Бумбат 1-р багийн малчин М.Нармандах, Ц.Батзориг, С.Гантулга, Моностой 2-р багийн малчин М.Телеужан нар хамрагдаж малчин өрхүүдэд 4500,0-5000,0 төгрөгийн мал худалдан авч малжуулах арга хэмжээ авлаа.

Зүүнбүрэн сум:

Аймгийн аудитын газрын ажлын хэсэг 2018 оны 6-р сарын 21-22-ны өдрүүдэд тус суманд ажиллаж төр, төсвийн байгууллагуудын үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ. Аймгийн замын сангийн 20 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар Жаргалант 1 дүгээр багийн нутаг дэвсгэрт 450 метр сайжруулсан зам тавигдлаа.

2018 онд 10468 га улаан буудай, арвай 367 га, овьёос 167 га, гурвалжин будаа 140 га, царгас 35 га, эрдэнэшиш 52 га, ногоон тэжээл 41,5 га, вандуй 33 га, рапс 1539 га нийт 12851,5 га талбайд 12 аж ахуйн нэгж, 2 иргэн, 36,29 га талбайд төмс, 303,65 га хүнсний ногоог 2 аж ахуйн нэгж, 209 өрх хийж гүйцэтгэл 94 %-тай биеллээ.

Уринш боловсруулалтыг 2018 оны захиалганд 5 аж ахуйн нэгж, 2 иргэний 2266 га талбайг, улаан буудай тариалсан талбайн соёололтын дүнг 12 аж ахуйн нэгж, 1 иргэн бүрээр гаргаж холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлжээ. Мөн аймгийн төв Сүхбаатар суманд зохион байгуулагдсан “Ногоочдын уулзалт, сургалт”-нд 11 ногоочныг хамрууллаа.

Сум хөгжүүлэх сангаас зээл хүссэн 11 иргэний төслийг хүлээн авч аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас мэдээлэл, лавлагаа авч шалгуурт нийцсэн 6 иргэний төсөл дээр сум хөгжүүлэх сангийн орон тооны бус зөвлөлийг хуралдуулж 3 иргэнд 14,0 сая төгрөгийн зээл олгохоор шийдвэрлэж, Нүүдэлчин малчдын мэдээллийн санг бүрдүүлэх анхдугаар судалгаанд 299 өрхийг хамруулан холбогдох дээд шатны байгууллагад хүргүүлжээ.

Бог малын ангилалтыг зохион байгуулж 7 өрхийн 1451 хонь, 135 ямааг ангилалтанд хамруулснаас хуц 204, ухна 135-ыг тус тус байна. 2018 оны малын хагас жилийн түүвэр судалгааг 06 дугаар сарын 4-11-ний өдрүүдэд зохион байгуулж 79 өрхийг хамруулж, 6 өрх, 1 аж ахуй нэгжид хяналтын тооллого явууллаа.

“Даван туулах дасан зохицох чадвартай орон нутгийн иргэд” хөтөлбөрт мал эмнэлгийн байгууллагуудыг хамруулснаар, Олон улсын MERCY CORPS байгууллагаас олгосон зөөврийн хашааг ашиглан, тарилгын технологийг баримтлан ажиллаж, 35900 толгой малыг халдвартбоом, дуутхавдар, шөвөгярөвчний дархлаажуулалтанд хамрууллаа.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас хэрэгжиж буй малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 6 иргэнийг хамруулж 27,0 сая төгрөгийг, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд 2 ахмад настныг хамруулж 1,120,000 төгрөг, гарааны бизнесийг дэмжих хөтөлбөрт 1 бүлгийг хамруулж 10,0 сая төгрөгийн зээлийг тус тус олголоо. Халамжийн сангаас олгож буй тэтгэвэр, тэтгэмжийг хугацаанд нь олгож, хүнсний цаасан эрхийн бичгээр үйлчилгээ үзүүлдэг “Идэр” хүнсний дэлгүүрийн 10 нэр төрлийн бүтээгдэхүүнд хугацаа, чанар, хадгалалт, үнэ зэрэгт хяналт шалгалт хийлээ. Тус дэлгүүр нь 2018 оны 01 дүгээр сараас 05 дугаар сар хүртэлх хугацаанд 22 өрхийн 117 иргэнд 10 нэр төрлийн хүнсний бараа бүтээгдэхүүнээр үйлчилж 6.680.00 төгрөгийн санхүүжилтийг аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газраас олгоод байна.

Нийгмийн даатгалын Ерөнхий газраас 2018 оныг "Нийгмийн даатгалын цахим үйлчилгээг хөгжүүлэх жил" болгон зарласантай холбогдуулан 06-р сарын 06-ны өдөр аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн албаны дарга, мэргэжилтнүүд тус суманд ажиллаж, даатгуулагчдад өөрийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлт, нийгмийн даатгалын сангаас гаргуулсан зардал, төлбөр, нийгмийн даатгалын үйлчилгээ болон Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаар мэдээлэл авах гар утасны аппликэйшнийг танилцуулж, бүртгэн баталгаажуулж, даатгуулагчдын сонирхсон асуултад тайлбар өгч ажиллалаа.

Халдварт болон халдварт бус өвчний эрт илрүүлэг, сумын Эрүүл мэндийн мэдээллийн цахим сан гбүрдүүлэх цогц оношлогоо, үзлэгийг 2018 оны 06 дугаар сарын 22-ноос 24-ний өдрүүдэд зохион байгуулж 700 иргэн хамрагдлаа.

2018 оны олон улсын Хүүхдийг эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлж 14 дүгээр цэцэрлэгийн хүүхдүүдийн дунд “Аав ээж би” тэмцээн, 4-5 насны хүүхдүүдийн дунд гүйлт, асуулт хариултын танин мэдэхүйн “АХА” тэмцээн, “Гэр бүлээрээ жаргалтай” гар зургийн уралдаан, Шатрын тэмцээнийг тус тус зохион байгуулж тэргүүн байр эзэлсэн хүүхдүүдийг алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, гарын бэлэгээр шагнаж урамшуулж, “Шаар хагалах” тэмцээнийг зохион байгуулж, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газраас зорилтот бүлгийн хүүхэд, багачуудад гарын бэлэг өгч, 4 ба түүнээс дээш олон хүүхэд төрүүлж өсгөсөн 8 эхийг алдарт эхийн 2 дугаар одонгоор шагнах ёслолын арга хэмжээг зохион байгуулж, “Алтан тариа” ХХК хамгийн олон ном уншсан 15 сурагч, амжиргааны баталгаажих түвшингөөс доогуур орлоготой 20 хүүхдэд тус тус гарын бэлэг гардуулж, баярын арга хэмжээнд хүрэлцэн ирсэн хүүхэд багачуудад таргаар үйлчиллээ.

Улсын аварга шалгаруулах жудо бөхийн тэмцээнд Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн 5а ангийн сурагч Н.Саранцогт 3 дугаар байр, Их богд уртын дуучдын улсын анхдугаар уралдаанд 10 дугаар ангийн Г.Одмаа 1 дүгээр шатанд 1-р байр, 2 дугаар шатанд тусгай байр, 12 дугаар ангийн сурагч М.Тэмүүжин Монгол туургатны “Миний монгол бичиг” уралдаанд 3 байранд тус тус шалгарсан байна.

“Хоймор нутгийн хийморлог Бүрэнчүүд” байгууллага сурталчлах өдөрлөгийн шилдэг номеруудын “Гала” тоглолтыг зохион байгуулж тэргүүн байрт “Ерөнхий боловсролын сургууль, дэд байрт “Үйлчилгээний байгууллага”, гутгаар байрт “Бэлчирийн 2 дугаар багийн иргэдийн баг шалгарч, шилдэг номеруудыг тус тус шалгарууллаа.

Мандал сум:

Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Эрдэнэбатын дэмжлэгтэйгээр Сэлэнгэ аймгийн Мандал сумын Засаг даргын Тамгын газар, Мандал сумын Нэгдсэн эмнэлэг, БНЭУ-ын Лахор эмнэлгийн нийгмийн нэгж, Пуса Роуд, Шинэ Дели, доктор Би Эл Капурын нэрэмжит “Эй би Нетвокс” эмнэлгүүд сумын ард иргэдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах, эмч эмнэлгийн ажилтнуудыг дадлагажуулан сургах, шаардлагатай тоног төхөөрөмжийн тусламж үйлчилгээг үзүүлэх хамтын ажиллагааны харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурлаа. Энэтхэгийн талаас Мандал сумын хүн амд жилд нэг удаа урьдчилан

сэргийлэх болон нарийн мэргэжлийн төрөлжсөн тусламж үйлчилгээг үзүүлэх эмчийн багийг ажиллуулж, сумын Нэгдсэн эмнэлгийн тусламж үйлчилгээг загвар болгон хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх юм.

Сумын удирдах ажилтны 3-р зөвлөгөөнийг “Хүүхдийн эрхийг хамгаалахад удирдах ажилтны оролцоо” сэдвээр зохион байгуулж, сумын хүүхдийн гэмт хэргийн өнөөгийн нөхцөл байдал, хүүхдийн өчвлөл, эрсдэлт бүлгийн хүүхдийн судалгаа, тугамдаж буй асуудал, хүүхэд хамгааллын хамтарсан багаас авч хэрэгжүүлсэн ажил, “Цахлай” хүүхэд хамгааллын сайн дурын байгууллагын үйл ажиллагааны талаар мэдээлэл хийж, сумын хүүхдийн төлөө зөвлөл, хүүхдийн хууль зүйн хороо, хамтарсан баг, Залуучуудын хөгжлийг дэмжих зөвлөл зэрэг суманд үйл ажиллагаа явуулж буй хүүхэд хамгааллын байгууллагуудын зохион байгуулалт, үүрэг оролцооны талаар хэлэлцэж, хүүхдийн эсэн мэнд, аюулгүй орчинд сурч боловсрох, амьдрах эрхийг хангах зорилго бүхий Засаг даргын зөвлөмжийг баталлаа.

Хүүхэд хамгааллын 30 хоног, Нэг хүүхэд нэг байгууллага, Нэг байгууллага нэг өрх ажлуудын хүрээнд 47 байгууллагат 42 зорилтот айл өрхийг хувиарлан өгч өрх, хүүхдийн сайн сайхны төлөө бүтэн жилийн аяныг зарлан хэрэгжүүлж байна.

Суманд үржүүлж буй сайн чанарын үржилд ашиглаж байгаа хээлтүүлэгчийн ашиг шимийн түвшинг тодорхойлж, үзлэг ангилалт, цөм сүргийг бүрдүүлэх, баталгаажуулах ажлыг зохион байгууллаа. 2018 оны эхний хагас жилийн байдлаар 1500 бог малд үзлэг ангилалт хийлээ.

Хадлан тариалангийн ургац хамгаалах тухай сумын засаг даргын захирамж гарч тариан талбайн ойролцоо өвөлжиж хаварждаг 32 малчин өрхөд зусланд буух мэдэгдэл хүргүүлж ажилласнаар малчид зусландаа бууж өвөлжөө хаваржааны бэлчээр малын хөлөөс чөлөөлөгдлөө. Түүнчлэн сумын ИТХ-ын 2014 оны 256 тоот тогтоолын дагуу гадны аймаг сумдаас зөвшөөрөлгүй отор нүүдэл хийж ирсэн 4 малчинд бэлчээр чөлөөлөх мэдэгдэл хүргүүлж сумын нутаг дэвсгэрээс гаргах ажлыг зохион байгууллаа. Бэлчээр, хадлангийн талбайн хортон мэрэгч устгалын ажлыг сумын хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй иргэд, орон нутгийн малчдыг оролцуулан утах, ус цутгах аргаар 4000 га талбайд устгал хийх ажлыг зохион байгууллаа.

Үр тариа, төмс, хүнсний ногооны нэгжээс авах ургацаар аймагтаа тэргүүлж, баталгаат хүнсний хангамжийг нэмэгдүүлэх зорилт тавин ажилласанаар 2018 онд 39 иргэн, аж ахуй нэгж байгууллага 7100 га-д улаан буудай, 126 га-а эрдэнэшиш, 725 аяга аяга тариаллаа. Үр тариа, тэжээлийн ургамал, тосны ургамлын нийт тариалалтыг 100 хувь уриншинд тариалсан байна. Үр тарианы үйлдвэрлэл эрхлэгч 34 аж ахуйн нэгж, байгууллага, иргэн 6400 га талбайг тариалангийн талбайн ургацыг мал тэжээвэр амьтдаас хамгаалах, малчид тариаланчдын хоорондын маргааныг бууруулах зорилгоор хашаажуулсан нь нийт тариалалтын 80,4 хувийг эзэлж байна.

Суманд ойгоос мод бэлтгэлийн үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг хамруулсан зөвлөгөөн, сургалтыг зохион байгуулж, ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, аж ахуйн нэгж, байгууллагуудын өнөөгийн байдал, мод бэлтгэлийн үйл ажиллагаанд гарч буй нийтлэг зөрчил, бэлчээрийн ашиглалт, доройтол, хөрсний эвдрэлийн шалтгаан нөхцөл, дээрх төрлийн гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Зөрчлийн тухай хууль Хөдөлмөр хамгаалал- Аюулгүй ажиллагааны аюулгүй байдал, Хог хаягдлын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгуулж 97 иргэнийг хамрууллаа.

Сумын төвөөс алслагдсан малчин өрхөд Төрийн үйлчилгээг хүргэх зорилгоор Төмөр замчдын 1-р багийн Дарьтын эхэнд суудаг малчин өрхийн дунд " Бид хамтдаа" өдөрлөг арга хэмжээг зохион байгуулж, төрөөс баримталж буй бодлого шийдвэр, хуулийн шинэчлэлтийн талаар мэдээлэл сурталчилаа хийж, нийгмийн халамжийн хууль тогтоомж, орлогыг орлуулан тооцох аргачлал, хүүхдийн мөнгө, бусад малчидтай холбоотой халамжийн талаарх асуудлууд, Байгаль орчны тухай хууль, ойг нөхөн сэргээх тухай, Мал амьтны эрүүл мэндийн тухай хууль, Малчны тэтгэвэр, ажилласан жил нөхөн тооцох тухай, сайн дурын даатгал, эрүүл мэндийн даатгалын тухай, малын халдварт өвчин, түүнээс яаж урьдчилан сэргийлэх, малчидтай

байгуулдаг гэрээ, малын хулгай, гэр бүлийн хүчирхийллийн талаар мэдээлэл хийж, өрхийн эрүүл мэндийн төвөөс урьчилан сэргийлэх үзлэг оношилгоо хийж, “Азын нахиа” эмийн сан урьдчилан сэргийлэх эм бэлдмэл, хөнгөлттэй эмээр малчдад үйлчиллээ. Уг арга хэмжээнд нийт 40 өрхийн 200 гаруй иргэд хамрагдлаа.

Орхонтуул сүм:

Сумын Засаг даргын Тамгын газраас иргэдэд хүргэх үйлчилгээг Олон Улсын жишигт нийцүүлэх зорилгоор Чанарын удирдлагын ISO9001:2015 стандарт нэвтрүүлэх ажлын хүрээнд албан хаагчдын ажлын бүтээмж цаг ашиглалтыг сайжруулж мэргэжилтэн бүрт 10 ширхэг хавтас авч бичиг баримтын эмх цэгцтэй байдлыг хангаж, төсвөөс 700,000 төгрөгийг зарцуулсан.

Энэ сард сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх 2018 онд хийгдэхээр батлагдсан ажлуудаас Баянцогт 2-р багт ухаалаг худагны тоног төхөөрөмж худалдан авах, Рашаант тосгонд сүү хөргүүрийн танк худалдан авах болон орон нутгийн хөрөнгө оруулалтаар хийгдэх Цэцэрлэгийн дээвэр, хаалга засварын ажлын тендерийг зарлаж өнөөдрийн байдлаар Баянцогт 2-р багт ухаалаг худагны тоног төхөөрөмж худалдан авах, цэцэрлэгийн дээвэр засварын ажлуудын гэрээ байгуулагдаж ажил нь эхлээд байна. Рашаант тосгонд сүү хөргүүрийн танк худалдан авах ажилд үнийн санал ирүүлсэн компани байхгүй тул дахин зарлагдана.

Аймгийн Засаг даргын эрх шилжүүлсэн зам, засвар тэмдэглэгээ, замын гэрэлтүүлэг, Эмнэлгийн морг, гражийн засварын ажлуудын тендерийг зарласан боловч мөн үнийн санал ирүүлсэн компани байхгүй тул дахин зарлаад байна.

Ингэснээр энэ онд хийгдэхээр батлагдсан ажлуудыг 100 цахимаар зарлаж хялбаршуулсан цахимаар 4 ажил, уламжлалтаар 1 ажил хийгдэж байгаа юм.

Олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр 6-р сарын 1-ний өдрийг тэмдэглэн өнгөрүүллээ. Хүүхдийн баярын арга хэмжээний хүрээнд сурлага, урлаг, спортын тэргүүний сурагчдыг шагнаж урамшуулахын дээр байгууллага бүр хүүхэд багачуудыг хөгжөөн баясгах чиглэлээр олон төрлийн үйл ажиллагаануудыг зохион байгууллаа. Сумын Засаг даргын Тамгын газраас жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Зайрмагны баяр” арга хэмжээ болон бусад үйл ажиллагаанд нийт 380,000 төгрөгийг зарцуулсан. Мөн Хүүхдийн баярын өдрөөр Алдарт эхийн одонгоор шагнагдах 13 ээжийн одонг гардуулж сумын Эмэгтэйчүүдийн холбооноос санаачлан зохион байгуулсан “Дархан бэр” арга хэмжээнд санхүүгийн дэмжлэг үзүүллээ. Төрийн бус байгууллагуудын үйл ажиллагааг дэмжих зорилтын хүрээнд “Сурын холбоо”, “Шагайн холбоо”-ны баг тамирчдыг улс, аймгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцоход нь санхүүгийн дэмжлэг үзүүлсэн.

Аймгийн хэмжээнд зохион байгуулагдаж буй “Ёс зүйн зөрчилгүй хамт олон” аяныг сумын төр, төсвийн байгууллагуудад хүргүүлж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тус суманд хөдөлмөр эрхэлж байгаа гадаадын иргэн, үйл ажиллагаа явуулж байгаа сүм, хийдийн мэдээг гарган аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтэст хүргүүллээ. Тус суманд өнөөдрийн байдлаар Рашаант тосгонд газар тариалангийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Шидэт хөрс” ХХК нь БНХАУ-н харъяат 3 иргэнийг хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулж байна.

Нийгмийн халамжийн сангаас олгож буй тэтгэвэр, тэтгэмжийг олгох ажлыг зохион байгуулж, “Ажлын байрыг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд 3 өрхийн 4 иргэнд 1,0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгт хамруулж, “Аж ахуй эрхлэлтийн сургалт”-нд 32 иргэнийг хамрууллаа.

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийг цаг хугацаанд нь олгож, 2018 оныг “Цахим үйлчилгээг хөгжүүлэх жил” болгон зарласантай холбогдуулан 6-р сарын 14-нд Төрийн банктай хамтран нийгмийн даатгалын тухай хуулийг сурталчлах, нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлэх, сайн дурын даатгалын шимтгэлийг шуурхай төлүүлэх, Қрау үйлчилгээ, зэрэг мэдээлэл сурталчилгааг хийж 30 гаруй иргэнийг хамруулан “Нийгмийн даатгал” апплейкшнийг 25 иргэн гар утсандаа суулгаж салбартай холбоотой мэдээллээ утаснаасаа авах боломжийг бүрдүүллээ.

2017-2018 оны хичээлийнжилийн үйл ажиллагаа дуусч сургуулийн гадна тохижилтын ажлууд хийгдлээ. Элсэлтийн ерөнхий шалгалт аймгийн хэмжээнд энэ сарын 16-20-ны хооронд 5 өдөр явагдаж нийт 29 сурагч элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн байна.

Сумын төвд “Монгол ви ти нет” ТББ-ны зуны цэцэрлэг, Рашаант тосгонд 24-р цэцэрлэгээс зуны цэцэрлэгийг тус тус ажиллуулж, нийт 40 гаруй хүүхэд хамрагдаж байна.

Сант:

Сумын Засаг даргын 2018 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 40 тоот захирамжийн дагуу малын хагас жилийн түүвэр тооллогын ажил зохион байгуулагдсан байна. Түүвэр тооллогт Хушаат багт 29 өрх түүвэрлэгдэн адуу 548, үхэр 1333, хонь 4061, ямаа 2803 тоологдон адуу 3, үхэр 37, хонь 8, ямаа 12 хорогдсон бол Ивэн багт 32 өрх түүвэрлэгдэн адуу 891, үхэр 1199, хонь 4692, ямаа 2481 тоологдон адуу 3, үхэр 32, хонь 3, ямаа 6 хорогдсон дүнтэй байна. Мөн сумын Засаг даргын захирамжаар хээлтүүлэгч малын үзлэг бог малын ангилалтыг зохион явуулах ажлын хэсгийг томилон ажиллуулж, 1300 нарийвтар ноост хонь хамрагдан орохоос 236 хонинд үзлэг ангилалт хийгдээд байна.

Хаврын тариалалтын ажил дуусаж нийт 3958 га талбайд улаанбуудай, 264 га талбайд тосны ургамал, 250 га талбайд төмс, 140 га талбайд 15 нэр төрлийн хүнсний ногоо тариалж 2018 оны тариалалтын ажил 117 хувийн гүйцэтгэлтэй хийгдсэн байна.

Бэлчээрийн мэрэгчидтэй байгаль орчинд халгүй аргаар тэмцэх ажлыг 3000 га талбайд хийсэн.

Сумын Засаг даргын аймгийн Засаг даргатай хамтран ажиллах гэрээнд заасны дагуу хөдөлмөр эрхлэлтийг дэмжих замаар 40 шинэ ажлын байр бий болгох зорилт тавин ажиллаж 6 дугаар сарын 19-ны байдлаар 23 шинэ ажлын байр бий болж төлөвлөгөөний гүйцэтгэл 58.0 хувьтай биелж, Малчдын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн малжуулах арга хэмжээнд сумын амьжиргааг дэмжих зөвлөлийн хурлын шийдвэрээр 6 залуу малчин өрхийг хамруулж ХЭДС-аас 25.200.000 төгрөгийн санхүүжилтээр 28 тугалтай үнээ 36 сарын эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр хүлээлгэн өгсөн байна. Мөн аймгийн ХХҮГ-аас Дархан-Уул аймгийн ЖДҮ-ийг дэмжих төвтэй хамтран аж ахуй эрхлэлтийг дэмжих хөтөлбөрийн хүрээнд "Бизнесээ эхэл, Бизнесээ хөгжүүл" бизнес төсөл боловсруулах сургалт зохион байгуулж хувиараа бизнес эрхлэгч 20 иргэнийг хамруулж аж ахуй эрхлэх батламжийн гэрчилгээ олголоо. Сумын түүхт 90 жилийн ойг угтсан бүтээн байгуулалтын ажлын хүрээнд сумын баяр наадмын талбайг тохижуулах ажлыг зохион байгууллаа.

Сумын ИТХ, ЗДТГ, Соёлын төв, 13-р цэцэрлэг хамтран олон улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тэмдэглэн өнгөрүүлж хүүхдүүдийн дунд бөхийн барилдаан, дугуйн уралдаан, гүйлтийн тэмцээн зэрэг урлаг спортын арга хэмжээнүүдийг зохион байгуулж 160 гаруй хүүхэд хамрагдсан байна. Эх үрсийн баярын арга хэмжээний үеэр сумын ИТХ-аас алдарт эхийн 2 дугаар одонг 9 ээжид гардуулж, ИТХ-ын эмэгтэй гишүүд зорилтот бүлгийн өрхийн 20 хүүхдэд, “Баяндарь” ХХК амьжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой эрсдэлт нөхцөл байдалд амьдарч байгаа 5 хүүхдэд гарын бэлэг өгсөн байна.

Сумын Залуучуудын холбооноос 6 дугаар сарын 23-нд Дэлхийн тамирчдын баярын өдөр, Олон улсын олимпийн өдрийг угтан “Марафон” гүйлтийн тэмцээнийг иргэдийн дунд зохион байгуулж, 50 гаруй залуучууд хамрагдсан.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 7,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар сумын эрүүл мэндийн төвийн барилгын урсгал засварын ажил хийгдэж дууссан.

Хушаат сум:

Сумын ИТХ-ын 7-р хуралдаанаар 2019 оны төсвийн төсөл, 2020,2021 оны төсвийн төсөөсөл, Хадлангийн талбайг иргэдэд гэрээгээр ашиглуулах тухай, Сумын баяр наадмын товыг товлох тухай, “Хог хаягдлын үйл ажиллагааг зохицуулах журам” батлах, “Аялал жуулчлалын хөтөлбөр” батлах тухай асуудлуудыг хэлэлцэн тогтоол

гарган баталлаа. 2 багийн ИНХурлыг сумын төв, Могой, Бумбат тохойн 3 чиглэлд хэсэгчлэн хуралдуулж тулгамдсан асуудлуудыг хэлэлцүүлэн иргэдээс санал хүсэлтийг авч шийдвэрлэлээ. Багийн өдөрлөгийг малчид олноор зусч буй Артойлбо, Могойд зохион байгуулж нийт 50 малчин оролцсон ба малчдад хуулийн гарын авлага тарааж 2019 онд ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх ажлын саналыг авлаа.

Эх үрсийн баярын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар 9 ээж “Алдарт эх-2” одонгоор шагнагдан Монголын гэр бүлийг алдаршуулах төв, сумын Эмэгтэйчүүдийн холбоо хамтран 6 ээжид “Дархан бэр” өргөмжлөлийг гардуулан алдаршууллаа.

Цагаан овоог тахиx ёслолын арга хэмжээг зохион байгуулж дааганы уралдаан, хүчит 32 бөхийн барилдаан, Урианхай сур харваа, шагайн тэмцээнүүдийг зохион байгууллаа.

Монголын Үндэсний Олон Нийтийн Телевизийн Нийгэм эдийн засгийн албатай хамтран “Унаач хүүхэд”, “Бөхийн мэх”, “Эмээл урлаач”, “Сурын харваа”, “Гийнгоо”, “Монгол дээл, бүс” нэвтрүүлэгүүдэд бичлэг хийлгэж Цагаан овоо тахилгын даага, сур, уяачдын талаар дүрс бичлэг авхууллаа.

Сэлэнгэ аймгийн ахмад шатарчдын аварга шалгаруулах тэмцээн- тус суманд зохион байгуулагдаж Сүхбаатар сумын харьяат шатрын спортын мастер Билэгсайхан 1-р байр, Сүхбаатар сумын харьяат Буриад 2-р байр, Сайхан сумын харьяат Ганболд 3-р байр, эмэгтэй Түшиг сумын харьяат Алтанцэцэг 1-р байр, Хушаат сумын харьяат Жанжмаа 2-р байр, Цагааннуур сумын харьяат Уранчимэг 3-р байр тус тус эзэллээ.

Сумын нийт газар тариалангийн эргэлтийн талбай 21630 га байгаа ба энэ онд 24 аж ахуйн нэгж, иргэн нийт 11945 га-д тариалж 9804 га-г уриншлахаар байна. Тариалсан үр тариа 9535 га байгаагаас улаанбуудай 9035 га, овьёос 475 га, арвай 25 га байна. Мөн тэжээлийн ургамал /вандуй/ 79 га, техникийн ургамал/ рапс/ 2336 га, буурцагт ургамал / шар буурцаг/ 40 га, ногоон тэжээл 20 га-д тариалаад байна. Нийт тариалсан үр тарианы талбай 9535 га, үүнээс онц 3311, сайн 4951, дунд 1273 га. Нийт үр тарианы талбайд онц сайны эзлэх хувь 8262 га буюу 86,6% байна. Төмс хүнсний ногооны тариалалтын хувьд 9 ААН, иргэд нийтдээ 452.0 га-д тариалсан ба 233.5 га-д төмс, 218.5 га-д хүнсний ногоо тариалаад байна.

Сумын ОНХсангийн 2,4 сая төгрөгийн хөрөнгөөр сумын төвийн нэгдсэн хогийн цэгийн хашааны гаднах хогийг түрж дотогшлуулан зам гарган цэвэрлээд байна. Мөн нүүрэн талын хашааг шинэчлэх ажил хийгдэж байна. Сумын хэмжээнд “Эзэнгүй хог хаягдал цэвэрлэх ажил” явагдан зам дагуу, Могойн голын эхэн болон голын дагуух хог хаягдлыг цэвэрлэх ажил хийгдлээ.

“Мерси кор” ОУБ-аас хэрэгжүүлж байгаа “Даван туулах дасан зохицох чадвартай орон нутгийн малчид” төслийн хүрээнд АНУ-ын ЭСЯ-ны Эдийн засаг, худалдааны атташе Жон, Мерси Кор ОУБ-ын хөтөлбөрүүдийн захирал Энхцэцэг нар ирж бидний хийж, хэрэгжүүлж буй ажилтай танилцаж, санал бодлоо солилцож, ажил хэргийн тухай халуун яриа өрнүүллээ. АНУ-ын North Dakota-гийн их сургуулийн үхрийн мэргэжилтэн Крис зочилж үхрийн аж ахуйн талаар зөвлөгөө өгсөн. Монголын Бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоо, аймгийн Бэлчээр ашиглагчдын холбоотой хамтран “Нүүдэлч малчдын мэдээллийн сан бүрдүүлэх” судалгааг хийсэн.

Энэ сард ажилгүйдлийн бүртгэлд шинээр ажил хайгч 4 иргэнийг бүртгүүлэн байнгын ажлын байранд 5 иргэнийг зуучиллаа. Нийтийн хамарсан ажлын хүрээнд “Ойн цэвэрлэгээ” төслийг хэрэгжүүлэн 2-р багийн нутаг Артойлбын Майхан толгойд зорилтот бүлгийн болон ажилгүй, оюутан 20 иргэнийг хамруулан 5 хоног ажиллуулж 2800.000 төгрөгийн цалин олголоо. Ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээ хөтөлбөрт байгууллагын хүсэлтийн дагуу боловсролын чиглэлээр 1 ахмад багш /Б.Тулга/ хамрагдан 164 цагийн хичээл, сургалт хийв.

ЕБС-иас “Мянган бүтээл”-ийн үзэсгэлэн гаргаж сургуулийн нийт багш, сурагчид, эцэг эхчүүд идэвхитэй оролцон аваргуудаа шалгарууллаа.

Хүдэр сум:

Тус суманд тариалангийн газар эзэмшигч 5 аж ахуйн нэгж, нэг иргэн тариалалт хийж улаан буудай төлөвлөгөө ёсоор 4700 га-д тариалалт хийхээс 6209 га-д тариалалт хийж төлөвлөгөө 110%-иар давуулан тариалалт хийлээ. Одоогийн байдлаар төмс 70 га-д, рапс 125 га, арвай 126 га, овъёос 208 га-д тариалж хүнсний ногоо 38 га-д хийгээд байна.

Хүдэр суманд хууль бусаар ашигт малтмал олборлож байгаа аж ахуй нэгжийн үйл ажиллагааг шалгах зөрчлийг таслан зогсоох, ажлын хэсэг байгуулагдан хяналт шалгалтыг 1 удаа хийсэн ба зохих зөвшөөрөлгүй уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явагдаагүй байна. Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийн хүрээнд “Монгол алт” чиглэлийн “Цагаан зүрийн гол”, Хүдэр гол дагуу усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын бүсийг тогтоож тэмдэгжүүлэх ажлыг хийлээ.

Ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөлүүдийг 2 постонд тогтмол ээлжээр ажиллуулж, ААНэгж байгууллагууд БОХУБайцаагч нар, цагдаагийн хэсэг болон ойн ангитай хамтран хөдөлгөөнт эргүүл шалгалт хийж байна.

Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдөр, хүүхдийн баярыг “Хүүхэд гэр бүлтэй жаргалтай” уриан дор тэмдэглэн өнгөрүүлж орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдээс 197 ширхэг бэлгийг олгож, дугуйн уралдаан, гүйлтийн тэмцээнийг насны ангиллаар зохион байгуулж, амжилттай оролцсон хүүхдэд шагналыг гарын бэлэгтэй гардуулсан. Мөн хурдан даагны уралдааныг зохион байгуулсан ба сумын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй байнгын асаргаанд байдаг 17 хүүхдийн гэрт зочилж нөхцөл байдалтай танилцаж хүүхдийн баярын гарын бэлэг гардуулсан.

2018 оны 06 сард нийгмийн халамжийн сангаас 207 иргэнд 21,955,430 төгрөг олгосон. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас Дархан уул аймгийн жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв Хүдэр суманд Аж ахуй эрхлэлтийн сургалт зохион байгуулж 15 иргэн хамрагдаж аж ахуй эрхлэх чадамжийн гардан авч, суманд үйл ажиллагаа явуулж байгаа Аж ахуй н нэгж болох 42 нэгжийн 352 ажилтны дэлгэрэнгүй судалгааг хүргүүлэв.

Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээг 54 иргэнд үзүүлж, сайн дурын даатгалд 2 даатгуулагч шинээр даатгуулсан бөгөөд тайлант сард 24 даатгуулагчийн 2,136,540 төгрөгийг нийгмийн даатгалын санд оруулж нийгмийн даатгалын дэвтэр 4 даатгуулагчид шинээр нээж, шинээр 2 өндөр насны тэтгэвэр, 1 тахир дутуугийн тэтгэвэр тогтоогдсон.

НЭГТГЭН БОЛОВСРУУЛСАН :

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН
ХЭЛТСИЙН АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН

Ш.ЭНХМАА

ХЯНАСАН:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА

Ө.СУВДАА